



# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.08.20 №32 (10709)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМАНД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга Батлан хамгаалах яаманд ажиллалаа.

Төрийн тэргүүнийг дагалдан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ө.Шижир, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Гансүх, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Л.Болд нарын албаныхан ажилласан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг Батлан хамгаалах яаманд хүрэлцэн ирэх үед төрийн хүндэт харуул хүндэтгэн угтав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Бүх цэргийн Их хар сүлдийн өргөөнд зочилж хүндэтгэл үзүүлсний дараа Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагуудтай уулзаж, Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар санал солилцлоо. Уулзалтад Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Д.Ганхуяг болон Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдах бүрэлдэхүүн оролцлоо.

Мөн энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга Батлан хамгаалахын үе үеийн сайд нарыг хүлээн авч уулзсан юм.

## ЭЛЧИН САЙДУУДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

### ЭЛЧИН САЙД КОБАЯАШИ ХИРОЮКИ

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяаши Хироюкиг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Япон Улсыг Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн гадаад бодлогод тэргүүлэх байр суурийг эзэлдгийг бүрдээд сүүлийн жилүүдэд хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт хурдацтай хөгжиж байгаагийн




дотор Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нэн ахицтай байгааг тэмдэглэн хэлсэн юм.

Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяаши Хироюкиг бүс нутгийн аюулгүй байдлын талаар зөвлөлдөж, Монгол Улс, Япон улсын Батлан хамгаалах салбарын харилцаа бүх түвшний харилцан айлчлал, зөвлөлдөх уулзалт хийж, цэргийн боловсон хүчнийг сургаж бүртгэх, хамтарсан сургалт дадлага явуулах зэрэг өргөн хүрээнд хөгжиж буйг тэмдэглэн Японы Өөрийгөө хамгаалах хүчин

Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй "Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чиглэлээр хамтарсан сургалт, дадлагыг цаашид амжилттай үргэлжлүүлэн, хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаа онцлон тэмдэглэв.

Уулзалтын төгсгөлд цар тахлын улмаас түр хугацаагаар хойшлогдоод байгаа хоёр талын салбарын төлөвлөгдсөн айлчлал, гадаад арга хэмжээг нөхцөл байдал сайжирсны дараа хэвийн үргэлжлүүлэхээр тохиролцоонд хүрэв.

### ЭЛЧИН САЙД Ж.Ж.АДИЛБАЕВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Ж.Адилбаевыг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр хоёр тал Монгол, Казахстаны ард түмний олон зуун жилийн түүхтэй найрсаг харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцож, түүний дотор Батлан

хамгаалах салбарын харилцаа жилээс жилд өргөжин хөгжиж байгааг харилцан тэмдэглэсэн юм.

Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Ж.Адилбаев Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт хандан Батлан хамгаалахын сайдын өндөр хариуцлагатай албанд томилогдсон явдалд баяр хүргэж, амжилт хүслээ.

### ЭЛЧИН САЙД М.П.СИНГХ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингхийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Энэтхэг Улсыг манай улсын "Гуравдагч хөрш", бүс нутаг дахь чухал түнш хэмээн онцлоод тус улстай хөгжүүлж буй стратегийн түншлэлийн харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгдөг гэдгийг тодотгосон юм.

БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингх Энэтхэг, Монголын харилцаа, хамтын ажиллагаа олон салбарыг хамран, өргөн хүрээнд амжилттай хөгжиж байгааг дурдаад хоёр орны Засгийн газар хоорондын бүхий л чухал төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалах салбарын гүйцэтгэх үүрэг чухал гэдгийг онцлон тэмдэглэв.

Уулзалтын төгсгөлд талууд хоёр талын хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байдлаар илэрхийлээд, цаашид батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг улам үр өгөөжтэй, өргөн цар хүрээнд хөгжүүлэх талаар санал нэгдсэнээр уулзалт өндөрлөсөн юм.

### ЭЛЧИН САЙД ФИЛИП МАЛОН



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ИБУИНХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Филип Малонийг Батлан хамгаалах яаманд хүлээн авч уулзлаа. Уулзалтаар талууд хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлэхдээ, Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын харилцаа нийгмийн бүхий л салбарт амжилттай хөгжиж байна. Тэр дундаа сүүлийн жилүүдэд Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаагийн жишээ нь цэргийн сургалт болон спортын чиглэлээр хамтарсан арга хэмжээ тогтмол зохион байгуулагдаж байгаа явдал бөгөөд цаашид олон чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байгааг тэмдэглэв. Түүнчлэн хоёр орны Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид энхийг дэмжих ажиллагаанд мөр зэрэгцэн амжилттай үүрэг гүйцэтгэж байгаагаа онцолсон юм.

Элчин сайд Филип Малон цэргийн мэргэжлийн алба хаагч Батлан хамгаалахын сайдаар томилогдсонд баяр хүргээд, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны чиглэлийг нэмэгдүүлж, хөгжүүлэхэд хамтарч ажиллахаа илэрхийлэв.



### ХҮҮХЭД, ЗАЛУУСТ ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ КОНТЕНТ БҮТЭЭНЭ

Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, хүүхэд, залууст эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний контент бүтээх зорилгоор Батлан хамгаалах яам, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичигт Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Ерөнхий захирал Л.Нинжжамц нар гарын үсэг зурсан юм. Санамж бичгийн хүрээнд Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагааг

олон нийтэд сурталчлан таниулахаас гадна улс орны батлан хамгаалах, эх орны бүтээн байгуулалтад гавьяат үйлс бүтээсэн цэрэг дайчдыг дэлгэцийн бүтээлд мөнхөлж, алдаршуулах мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгүүдийг хамтран бэлтгэж олны хүртээл болгохоор төлөвлөжээ.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлэхдээ "Батлан хамгаалах салбар Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизтэй өнгөрсөн он жилүүдэд үр бүтээлтэй хамтарч ажиллаж ирсэн. "Эх орны төлөө" нэвтрүүлэг долоо хоног бүр үзэгчдийн

хүртээл болж, батлан хамгаалах салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсаар байна. Ирэх 2021 онд Батлан хамгаалах яам үүсэн байгуулагдсаны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохионо. Түүхт ойл тэмдэглэн өнгөрүүлэхэд Батлан хамгаалах яам голлох үүрэг гүйцэтгэж, үндэсний ууган хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран түүхт ойдоо зориулан олон нэвтрүүлэг, баримтат кино, дэлгэцийн бүтээлүүдийг бэлтгэх ажлын эхлэл нь өнөөдрийн санамж бичгийг үзэглэснээр тавигдаж байна" гэдгийг онцолсон юм.

## РЕДАКЦИЙН ЗУРВАС

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний төв хэвлэл "Соёмбо" сонин нь Монгол Улсын ууган хэвлэл мэдээллийн байгууллагын нэг бөгөөд иргэний нийгэмд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, мэдээ, мэдээллийг тогтвортой, шуурхай хүргэх, уншигчдад эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх эрхэм үүргээ 96 дахь жилдээ нэр төртэй гүйцэтгэж байна.

Тус сонины гүйцэтгэсэн үүрэг, түүхэн ололт амжилтыг Монгол Улсын төр, засгаас өндөрөөр үнэлэн сонины 25 жилийн ойг тохиолдуулан 1949 онд Байлдааны гавьяаны улаан тугийн одон, 50 жилийн ойн баяраар 1974 онд Сүхбаатарын одонгоор тус тус шагнасан бөгөөд хэвлэл мэдээллийн салбарын 2010, 2013, 2014 оны шилдэг сонингоор шалгарсан түүхэн амжилтаар бид бахархдаг юм.

Тус сониныг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний ангиудын офицер, ахлагч нар 100 хувь захиалан уншсанаар салбарт өрнөж буй үйл явдлын талаарх мэдээллийг шуурхай, тогтвортой авах боломж

улам бүр нэмэгдлээ. Үүний зэрэгцээ тус сонины редакцын саналыг үндэслэн Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын дэмжлэгтэйгээр аймгуудын Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ажилтнууд 2019 оноос, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ажилтнууд энэ оны эхний улирлаас 100 хувь сонингоор захиалан уншдаг болоод байна.

Сонины уншигч, захиалагчдын тоог нэмэгдүүлэх, зөвхөн цэргийн алба хаагчдаар хязгаарлахгүй, иргэний нийгэм, гэр бүл, найз нөхдийнхөө хүрээнд салбарын бүтээлч үйл ажиллагааг сурталчлах ажлыг дэмжиж энэ оны гуравдугаар улирлаас эхлэн Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Сайдын зөвлөх, туслах, хэвлэлийн төлөөлөгч, жолооч болон Сайдын зөвлөлийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ тус сониныг албан ёсоор захиалан байнгын хэрэглээ болгож байгаад чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлэе.

Сонины нийт уншигч, захиалагчдаа аялын арвин их амжилтыг бэлгэдэн ерөөе.

"СОЁМБО" СОНИНЫ РЕДАКЦИ

## ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨЛӨӨ



Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн "Шархад" хээрийн сургалтын төвд ОХУ, БНСУ-ын цэргийн их, дээд сургуульд суралцах сонсогчид болон Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудад офицер, ахлагчийн албан тушаалд туршилтын хугацаанд томилогдон ажиллаж буй бүрэлдэхүүний цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаа боллоо. Ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Д.Баасандамба, УБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан нарын хүндэт зочид, цэргийн тангараг өргөж буй бүрэлдэхүүн, тэдний ар гэрийн төлөөллүүд оролцлоо.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Цэргийн тангараг өргөсөн сонсогчид хандаж хэлсэн үгэндээ "Гадаадын цэргийн сургуульд суралцахаар хилийн чанадыг зорьж буй та бүхэн эрдэм, мэдлэгт шамдан суралцаж, ихийг сурч ирээд Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлт, Батлан хамгаалах салбартаа ихийг хийж бүтээнэ гэдэгт бид итгэл төгс байна.

Та бүхэн гадаадын их, дээд сургуулийн сургалтын тогтолцоо, түүний хөтөлбөр, тавигдах шаардлагад өөрсдийгөө нийцүүлэх хэрэгцээ бий болоод байгааг бид мэдэж байгаа.

Хэлний мэдлэгээ сайжруулан өөрсдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэн хариуцлагатай байж, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөж яваарай" гэж захив. Тэрээр үргэлжлүүлэн Батлан хамгаалах бодлогын шинэчлэл болон дээд боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд Цэргийн сургуулийн сонсогчдыг суралцах хугацаанд нь тэдэнтэй байнгын холбоотой байж боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг нь яамны удирдлага бүхий л талаар дэмжин ажиллах болно гэдгийг онцолсон юм.

Цэргийн тангараг өргөсөн сонсогчид дээрх хоёр улсын талаас цаг үеийн нөхцөл байдал сайжирч, сургалт хэвийн явагдах хүртэлх хугацаанд Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн Гадаад хэлний сургалтын төвийн дамжаанд суралцах аж.

**Г.Сэргэлэн: САЙН БОЛОВСОН ХҮЧИН БОЛЖ ИРНЭ**

-Сонгон шалгаруулалтад тэнцэж ОХУ-ын Краснадр хотын Цэргийн нисэхийн их сургуульд суралцахаар боллоо. Эмээгийн маань ах Т.Сугар гэж гавьяат нисгэгч хүн байсан. Тэр хүнийг харж өссөн болохоор бага байхын л том болоод нисгэгч болно доо гэсэн хүсэл төрдөг байв. Цэргийн анхан шатны сургалтаа дуусгаад цэргийн тангаргаа өргөж цолоо авлаа. "Тэмүүжин-Өрлөг" сургуульд зургаан жил суралцсан учраас суурь гайгүй тавигдсан гэж болно. Гэхдээ

сургалтын явцад мэдэхгүй чадахгүй зүйл бишгүй дээ л гарч байсан. Сонсогчийн батальоны чадварлаг офицер, ахлагч нарынхаа ачаар чамгүй зүйлийг сурч мэдлээ. Гэр бүл, найз нөхөдөө хэлэхэд, та нарынхаа итгэлийг алдалгүй сайн боловсон хүчин болж ирнэ.

**Х.Цэмбэлдорж: ӨӨРИЙГӨӨ ЗЭРГЭЭР ӨӨРЧИЛЖ ЧАДЛАА**

-Цэргийн амьдралын гоё сайхныг олон хүнээс сонсож байсан. Нүдээр үзэж, биеэрээ мэдрээгүй болохоор тэр үедээ тийм л байх гэж бодоод л өнгөрдөг байж дээ. Харин Х.Цэмбэлдорж өөрөө өнгөрсөн өдрүүдэд тэр бүх зүйлийн зах зухаас нь мэдэрдээ. Эртэч байж сурлаа, эмх цэгцтэй байхыг ягштал мөрддөг боллоо. Бас өмнө нь гүйж чаддаггүй байсан бол одоо ч түүртэхээ больсон шүү. Энэ мэтчилэн өөрийгөө зөргөөр өөрчлөгдсөн гэж бодож байна. Энэхүү сургалтын үр өгөөжийг харамгүй хүртлээ. Төгсгөлд нь цэргийн тангаргаа өргөлөө. Омогших мэдрэмж төрдөг л юм байна, сайхан байлаа. Хүний амьдралд ганц тохиох мөч, ховорхон завшаан. Өвөө, аав маань цэргийн хүн л дээ. Энэ залгамж халааг авах гэж бас өөрийнхөө хүсэл сонирхолд тулгуурлаж цэргийн амьдралыг эргэлт буцалтгүй сонгосон. ОХУ-д барилгын дулааны инженер мэргэжлээр суралцах ховорхон завшаан тохиоод байна. Монгол Улсынхаа төлөө зүтгэе.

## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 110, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН ЛОГО, ПОСТЕРИЙН УРАЛДААН

Батлан хамгаалах яам нь 2021 онд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Батлан хамгаалах яам/ үүсэн байгуулагдсаны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ ажлын хүрээнд Лого болон Постерийн уралдааныг нийт алба хаагч, уран бүтээлчдийн дунд зарлаж байна.

**Хугацаа:**

Бүтээлийг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 15.00 цаг хүртэлх хугацаанд хүлээн авна.

## УРАЛДААНД ОРОЛЦОХ БҮТЭЭЛ НЬ ДАРААХ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА

| ЛОГО  | ПОСТЕР   |
|---|--|
| -Лого нь видео, сурталчилгааны самбар, сонин, сэтгүүл, ил захидал, зурагт хуудас, даавуун болон бусад материал дээр хэвлэх боломжтой байна.<br>-Лого нь JPEG өргөтгөлтэй өндөр нягтралтайгаар хадгалагдсан байна.   | -Хэл: Монгол, Орос, Англи;<br>-Хэмжээ: 40x60;<br>-Бүтээлийн доторх аливаа үг, үсэг, агууламж нь 1 метрийн зайнаас тодорхой харагдахаар дүрслэгдсэн байх. |
| -Утга санаа, агуулга нь Батлан хамгаалах яамны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийг тусгасан байх;<br>-Уралдаанд нэг оролцогч хэдэн ч загвараар оролцож болно;<br>-Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж өгөхгүй бөгөөд шалгарсан бүтээл нь Батлан хамгаалах яамны өмч байна. |  |

## Редакцын шууданд

**016 дугаар нэгтгэл**

2019-2020 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу Ахлагчийн зөвлөлөөс санаачлан ерөнхий цэргийн саадын зурвасыг цэргийн биеийн тамирын зааврын дагуу шинээр төхөөрөмжиллөө. Нээлтийн арга хэмжээнд ЗХЖШ-ын Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ, Хуурай замын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр нар оролцлоо. Энэ үеэр "Саадын зурвасыг хэн богино хугацаанд туулах вэ" тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд эрэгтэйчүүдийн төрөлд ахлагч Н.Энхсайхан, дэд ахлагч Г.Анхбаяр, Г.Гантогтох, эмэгтэйчүүдийн төрөлд дэслэгч Ц.Бадамсүрэн, дэд ахлагч С.Отгон-Эрдэнэ, Ш.Баасансүрэн нар амжилттай оролцож өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль хүртлээ.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

**013 дугаар анги**

Ангийн захирагчийн нэрэмжит сургуулийн жилийн хоёрдугаар үеийн төгсгөлийн шалгалтын дүнгээ гаргалаа. Мөн батальон, салбаруудын дунд "Тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах уралдааныг зохион байгуулж байна.

Ахмад Ц.ЦЭВЭГДОРЖ

**167 дугаар анги**

Гэр бүлийн эерэг харилцаа, хандлага, үр хүүхдэдээ зөв үлгэр дуурайлыг үзүүлэн нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэхэд нь эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор нийт алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийг урьж "Гэр бүлийн сургалт"-ыг зохион байгууллаа.

Сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний

## ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭЛТ АВНА

2020-2021 оны хичээлийн жилд дараах хөтөлбөрөөр суралцагч элсүүлнэ. Үүнд:

**Магистрын хөтөлбөр:**

1. Батлан хамгаалах судлал;
2. Зэвсэгт хүчний байгуулалт;
3. Цэргийн урлаг/стратег, оператив, тактик/;
4. Цэрэг захиргааны удирдлага /ХЗЦ-ийн, АДХ-ийн, ХЦ-ийн, ТТМЦ-ийн/;
5. Төрөл, тусгай мэргэжлийн цэргийн урлаг;
6. Байлдааны техник, зэвсгийн инженерчлэл;
7. Цэргийн сэтгэл зүйн хангалт;
8. Цэргийн материал, техникийн хангалт;
9. Цэргийн сургалт судлал;
10. Цэргийн түүх судлал;
11. Хуягт танкийн техник;
12. Цэргийн авто, гинжит машин;
13. Цэргийн зэвсэглэл, техник судлал;
14. Байлдааны хангалт;
15. Артиллерийн зэвсэглэл;
16. Зенитийн пуужингийн зэвсэглэл;
17. Зенитийн артиллери-электроник;
18. Цэргийн зэвсэглэл;
19. Холбооны техник хэрэгсэл;
20. Цэргийн удирдлагын автоматжуулалт;
21. Цэргийн химийн техник, зэвсэг;
22. Радио техник;
23. Цэргийн инженерийн техник;
24. Цэргийн зам, гүүрийн инженер;
25. Цэргийн тусгай барилдаа байгууламж;
26. Аюулгүй байдал судлал;
27. Төрийн удирдлага.

**Докторын хөтөлбөр:**

1. Батлан хамгаалах судлал;
2. Зэвсэгт хүчний байгуулалт;
3. Дайн, цэргийн урлаг судлал;
4. Цэргийн удирдлага;
5. Дайны бус цэргийн ажиллагаа;
6. Цэргийн сургалт судлал;
7. Цэргийн түүх судлал;
8. Цэргийн зэвсэглэл, техник судлал;
9. Аюулгүй байдал судлал.

Тус сургуулийн магистрын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч нь бакалаврын зэрэг, докторын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч нь магистрын зэрэг эзэмшсэн байна.

Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид 2020 оны 9 дүгээр сарын 1-18-ны өдрүүдэд Хичээлийн нэгдүгээр байр, Ахисан түвшний сургалтын албаны 211 тоотод ирж бүртгүүлнэ үү.

**Бүртгүүлэхээр ирэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:**

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- Элсэн суралцах өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Магистрын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын диплом, хавсралтын эх хувийг наториатаар баталгаажуулсан хуулбарын хамт;
- Цээж зураг 2 хувь;
- Бүртгэлийн хураамж 20000 төгрөг.

**Элсэлтийн шалгалт:** 2020 оны 9 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд хичээлийн нэгдүгээр байрны 208, 209 тоот өрөөнд 09.30 цагт эхэлнэ.

Шалгалтын нэгдсэн дүнг 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр [www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn) сайтад байршуулна.

Магистр, докторын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгчдээс дараах шалгалтыг авна.

- Мэргэжлийн шалгалт
- Ярилцлага (бүртгүүлэгч нь ярилцлагад орохдоо бүтээлийн жагсаалт, магистрын ажил, диссертац бичих сэдвийн танилцуулга, бүтцийн төлөвлөгөө авч ирнэ.)

**Харилцах утас, E-mail хаяг:**

Ахисан түвшний сургалтын алба: 86100101, 99092890, 89110773, [www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn)

**ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУВААРЬ****Магистрын хөтөлбөрт элсэгчдээс:**

| Д/д | Шалгалт авах чиглэл | Огноо      | Цаг         | Шалгалт авах хэлбэр      | Шалгалт авах газар                                     |
|-----|---------------------|------------|-------------|--------------------------|--|
| 1   | Мэргэжил            | 2020.09.22 | 10.00-11.30 | Бичгээр                  | 208 тоот   |
| 2   | Сэдвийн             | 2020.09.23 | 14.00-16.00 | Сонгосон сэдвээр бэлдсэн | 208 тоот   |
| 3   | Нэгдсэн дүн         | 2020.09.28 | 14.00       |                          | <a href="http://www.mndu.gov.mn">www.mndu.gov.mn</a> . |

**Докторын хөтөлбөрт элсэгчдээс:**

| Д/д | Шалгалт авах чиглэл     | Огноо      | Цаг         | Шалгалт авах хэлбэр      | Шалгалт авах газар                                     |
|-----|-------------------------|------------|-------------|--------------------------|--|
| 1   | Мэргэжил                | 2020.09.22 | 10.00-11.30 | Бичгээр                  | 209 тоот   |
| 2   | Сэдвийн ярилцлага       | 2020.09.23 | 14.00-16.00 | Сонгосон сэдвээр бэлдсэн | 209 тоот   |
| 3   | Нэгдсэн дүн танилцуулга | 2020.09.28 | 14.00       |                          | <a href="http://www.mndu.gov.mn">www.mndu.gov.mn</a> . |

## ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

дагуу "Centurions" буюу "Цэргийн нөхөрлөл" олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан юм. Тус байгууллагын багш Б.Ганхүлэг "Нөхөр, эхнэрийн үүрэг", багш Д.Төгөлдөр "Ярилцах арга ба зөрчлийг шийдвэрлэх нь" сэдэвт сургалтыг явуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн нь цэргийн алба хаагчдын гэр бүлийн гишүүд хоорондын эерэг харилцааг нэмэгдүүлэх, зөрчлийг оновчтой шийдвэрлэх, үр хүүхдэдээ зөв үлгэр дуурайлал үзүүлэн тэднийг хүмүүжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулснаараа ач холбогдолтой байлаа.

Энэ үеэр "Цэргийн нөхөрлөл" олон улсын байгууллага нь хамтран ажиллагч "Samaria бэлэг" олон улсын хүүхдийн байгууллагаас ирүүлсэн бэлгийг ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын хүүхдүүдэд гардуулан өгөв.

Ахмад Ё.БАТ-ЭРДЭНЭ

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛД

## Хурандаа Ж.Өсөхбаяр: ШТАБЫН БОЛОН ЦЭРГИЙН БАЙРАА БҮРЭН ШИНЭЧИЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр Зэвсэгт хүчний 167 дугаар ангид ажиллалаа. Тус ангийнхан үндсэн үүрэг гүйцэтгэлтээс гадна бүтээн байгуулалт өрнүүлээд тун завгүй. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд хэд хэдэн объектууддаа бүрэн хэмжээний засвар, шинэчлэл хийж, ЗХЖШ-ын “Штабын бэлтгэл”-ийн үзлэг, шалгалтад бэлдэж байв. Энэ үеэр тус ангийн захирагч, хурандаа Ж.ӨСӨХБАЯРТАЙ ярилцлаа.

Танай ангид хийгдэж буй засвар, тохижилтын ажлуудын талаар тодруулахгүй юу?

–Өөрсдийн нөөц бололцоогоор том, том объектууддаа засаж шинэчлэх боломж үндсэндээ байхгүй. Гэхдээ боломжгүй гээд



гараа хумиад суухыг хүссэнгүй. Орон нутгийн удирдлагуудтай энэ чиглэлээр нягт хамтран ажиллаж, тусалцаа авч байна. Тухайлбал, ангийн штаб, цэргийн байрандаа орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэмжээний их засвар орууллаа. Ёстой нөгөө ханыг нь дахин өрөхөөс л бусдыг нь шинэчилж байгаа. Сангийн шугам, цахилгааны монтаж, таазыг нь бүрэн сольж, дээврийг дулаалж цутган, гадна дулаалгыг ч хийлээ. Дотоод заслаа өрөөний систем руу оруулж засаж байна. Бид 2020 оны хоёрдугаар ээлжээр татагдах хугацаат цэргүүдээ цоо шинэ орчинд хүлээж авна. Штабын байр, эмнэлгийн байраа ч бүрэн шинэчилж байна. Ангийн эмнэлэгт тусгай зөвшөөрөл байхгүй. Цаашдаа бие бүрэлдэхүүнийхээ эрүүл мэндийг бодсон ч тэрхүү тусгай зөвшөөрлийг авах шаардлага байгаа тул үүнд чиглүүлэн засварлаж байна. Аймгийн Бүсийн оношилгооны төв болон Мэргэжлийн хяналтын газрынхныг урьж, заавар, зөвлөмж ч авсан. Урсгалын зөв дараалалд оруулан эрүүл ахуйн стандартад нийцүүлж, хэвтэн эмчлүүлэгчдийнхээ өрөө, тасалгаа, орны тоог нэмэгдүүлж байгаа. Хэрэв тусгай зөвшөөрлөө авчихвал байнгын бие бүрэлдэхүүндээ эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ч боломжтой болно. Үүнээс гадна дотоод нөөц бололцоогоо ашиглан цэргийн гал тогоог шинэчилж, боловсруулах цехээр нь тусгаарлалаа. Энэ нь мах, ногоо, гурилаа тус, тусдаа өрөөнд боловсруулах боломжтой болсон гэсэн үг. Үүнд манай ахлах тогооч болон хүнсний албаныхан их үүрэг оролцоотой байсныг дурдах нь зүйтэй. Ер нь манай хамт олон нэгнээ дэмжсэн, нягтарсан, баг болж ажиллах чадвартай залуусаар дүүрэн. Нэг нь бүтээлч ажил, арга хэмжээ санаачлахад бусад нь дэмжээд л аваад явчихдаг. Тэд маань дотооддоо уралдаан зарлаж, ангийн зам талбай, гэрэлтүүлгээ шинэчилж засварласан байгаа. Мэдээж бүтээн байгуулалтын бүх ажлаа өөрсдийн хүчээр хийж байна.

**Чөлөөт цагийн төв болон номын сангаа ч шинэчилж байгаа юм байна ...**

–Тийм ээ, бие бүрэлдэхүүнийхээ чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэн спортоор хичээллэж, номтой ойрхон байгаасай гэсэндээ энэ хоёр төвөө засварлаж байна. Мөн төрөл мэргэжлийнхэн, албад, салбарууд, зөвлөлүүд нэг нэг ажил хариуцаж аваад, гүйцэтгэл сайтай биелүүлж байна. Манай ар талын албад гэхэд ар талын дүрэм, журам, зааврынхаа дагуу агуулахуудаа цэгцэлж байх жишээтэй. Бид эхний ээлжид хүнсний нөөцийн агуулахаа цэгцэллээ. Үргэлжлүүлээд бусад агуулахаа тодорхой хэмжээнд засварлана. Одоо манай ангийнхны хүлээж байгаа хамгийн том ажил бол ЗХЖШ-аас зохион байгуулж байгаа “Штабын бэлтгэл”-ийн үзлэг, шалгалт юм. Өвөлжилтийн бэлтгэл ажил болон дээрх үзлэг, шалгалтын хүрээнд эдгээр бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлээ.

**Аймгийн удирдлагууд “Зэвсэгт хүчний 167 дугаар ангигүйгээр манай ямагт ямар ч томоохон ажил, арга хэмжээ явагддаггүй. Цэргийнхэн орон нутагтаа үлгэрлэгч байдаг” гэж онцолж байсан. Орон нутагтаа иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд ямар**

**ажил өрнүүлж байна вэ?**

–Дэлхий дахинд тархсан цар тахлын нөхцөл байдлын улмаас олныг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад хүндрэлтэй байна. Бид “Монгол цэргийн өдөр”-өөр төв талбайдаа “Нээлттэй хаалганы өдөр” өдөрлөг явуулж, цэргийн ёслолын жагсаалаар ахилдаг. “Энхийг сахиулагчийн өдөр”-өөр ч гэсэн энхийг сахиулагч офицер, ахлагч нар маань ерөнхий боловсролын сургуулиудад ярилцлага, уулзалт хийдэг. Энэ жил харин олныг хамарсан уулзалтаас илүү хувь хүн рүү ажил, арга хэмжээг илүүтэй зохион байгуулж явууллаа. Жишээлбэл, нийгмийн хариуцлагын хүрээнд амьжиргааны түвшин доогуур, олон нялх хүүхэдтэй, өрх толгойлсон хоёр айлыг сонгож аваад хашааг нь засварлаж, түлээ түлш, хэрэгцээтэй хүнсний бүтээгдэхүүнээр тусалсан. Хэдийгээр цоо шинэ өргөө цагаан гэр, шинэ хашаа бариад өгч чадахгүй ч гэсэн өөрсдийнхөө боломж бололцоонд тохируулан засварлаж, шинэчиллээ. Түүнчлэн орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Жолооны курсүүдтэй хамтран офицер, ахлагч, ажилтан албан хаагч, тэр бүү хэл цэргийн гэрээт алба хаагч болон хугацаат цэргүүдээ жолооч болголоо. Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвтэй хамтран барилга-инженерийн хэрэгцээтэй мэргэжлүүдээр мөн сургаллаа. Насан туршийн боловсролын төвтэй хамтран офицер, ахлагч нартаа энгийн мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж байна. Хэзээ нэгэн цагт тэтгэвэрт гарч, энгийн байгууллагад ажиллах шаардлага гарах үед ямар ч ажлыг түүртэлгүй хийчихдэг байх ёстой шүү дээ. Амьдралд нь хэрэгцээтэй мэргэжлүүд учраас манай бүрэлдэхүүн ч дуртайяа хамрагдаж байна. Даланзадгад сумын Засаг даргын дэмжлэгтэйгээр ангидаа “Камер” төслийг хэрэгжүүлэхээр боллоо. Ингэснээр ангийн өдөр тутмын үйл ажиллагаа болон сургалт бэлтгэлүүдийг бүрэн хянах боломжтой болж байгаа юм. Мөн аймгийнхаа эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх уулзалт, ярилцлагыг явуулж, үзлэг, оношилгоонд хамрагдаж байна. Энэхүү хамтын ажиллагаа нь тус ангийн өмнөх үе үеийн захирагч, удирдлагуудын үлдээсэн суурь хөрс юм. Энэ суурь хөрс өнөөдөр ч гэсэн амжилттай сайхан үргэлжилж байна.

**Цэргийн хүний үндсэн хөдөлмөр нь сургалт юм. Энэ тухайд ...**

–2019-2020 оны сургуулийн жилд манай ангийн сургалт бэлтгэл огт тасалдаагүй. Ялангуяа, цэргийн гэрээт алба хаагч болон хугацаат цэргүүдийнх. Бүрэн хэмжээний тоноглогдсон Бүсийн сургалтын төв дээрээ цар тахал идэвхжсэн 1-4 дүгээр сард бид цэргийн гэрээт болон хугацаат цэргүүдийнхээ сургалтыг явуулж чадсан. Ингэснээр нэгдүгээрт, сургалт бэлтгэл тасалдаагүй. Хоёрдугаарт, тэдний аюулгүй байдал, эрүүл мэндийг бодож вакуумжуулсан орчинд сургалтаа явуулсан юм.

**Бас Англи хэлний сургалтын төв байгуулсан гэсэн ...**

–Бие бүрэлдэхүүнийхээ гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд Англи хэлний сургалтын төв байгуулсан. Ахлагчийн зөвлөлөөс санаачлан хийж хэрэгжүүлсэн ажил юм. Төв маань мэргэжлийн багштай. Алба хаагчид ч тун идэвхтэй хамрагдаж байна. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдаа үүнд хамруулж байна. Өнөөдөр Зэвсэгт хүчинд өндөр боловсролтой цэргүүд ирж байгаа бөгөөд тэд нэг жилийг илүү завгүй, улам үр бүтээлтэй өнгөрүүлэх хүсэлтэй болчихож. Сургалт бэлтгэлийнхээ зэрэгцээ “Дарга аа, би сурмаар байна” л гэх юм. Хоёрдугаарт, англи хэлний сургалт яваагүй өдөр нь компьютеруудыг нь ашиглан зарим бүрэлдэхүүнийхээ компьютер дээр ажиллах чадварыг нь нэмэгдүүлж байна. Манай залуус ийм л завгүй байна даа.

**Тулгамдаж байгаа асуудал байгаа л байх ...**

–Тулгамдаж байгаа асуудал олон бий. Аль болгоныг нь тоочиж барах вэ. Бидний хувьд БХЯ, ЗХЖШ болон ХЗЦК-даа зовлон тоочихоос илүү аль болох дотооддоо шийдвэрлэж, зохицуулах талд анхаарч байна. Гэхдээ бас зохицуулж болдоггүй ажил гэж байна. Энэ бол алба хаагчдын орон сууцны асуудал юм. Манайх албан тушаалын гурван байртай. Энэ гурван байрны ердөө нэг нь л орон сууцны зориулалттай бусад нь агуулах байсныг засаж тохижуулж, айлуудаа оруулсан юм. Тийм болохоор бид бүхэн албан тушаалын орон сууцтай болох туйлын хүсэл мөрөөдөлтэй яваа. Өмнөговьд орон сууцны түрээс өндөр байдаг учир шинээр томилогдож ирсэн алба хаагчдаа “Түрээсийн байр олоод ороорой” гэж бас хэлж чадахгүй юм. Би ч гэсэн тэдний адил залуу явсан учраас аль болох нөхцөл, бололцоог нь шийдвэрлэхийн төлөө явдаг ч орон сууцны хүрэлцээ бол үнэхээр хүрдэггүй юм.

Тэртээ 1973 онд Өмнийн цэнхэр говьд үүдээ нээсэн БНМАУ-ын баатар, залуу жанжин, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит энэхүү ангид алба хааж байгаа зарим офицер, ахлагч, ажилтан алба хаагч, хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэгдлээс нь хуваалцлаа.

## ЦЭРЭГТЭЙ АЖИЛЛАЖ БАЙГАА МИНЬ НЭР ТӨРИЙН ХЭРЭГ

Салааны захирагч, дэслэгч Г.ПҮРЭВДОРЖ:

–Миний хувьд 2013 онд ҮБХИС-д элсэн суралцаад үргэлжлүүлээд БНХАУ-ын Хятадын Ардын Чөлөөлөх Армийн Хуурай замын цэргийн дээд сургуульд суралцаж төгссөн. Энэ ангидаа алба хаагаад хоёр жил болж байна. Сургуулиа төгсөж ирэхэд хүний нөөцийн офицерууд надаас “Та хаана ажиллах хүсэл сонирхолтой байна вэ” гэж асуухад нь шууд л “Хөдөө ажиллаж байвал хаашаа ч яах вэ” гэхэд энэ ангид томилсон. Хугацаат цэрэгтэй ажиллаж байгаага би нэр төрийн хэрэг гэж боддог. Эх орноо хамгаалахын үнэ цэн, эр цэргийн үүргийг цэргүүддээ ойлгуулж байгаа минь ч нэр төрийн хэрэг. Цэрэгтэй ажиллаад ирэхээр өөрийн эрхгүй хайрлаж эхэлдэг юм билээ. Цаашдаа илүү олон хугацаат цэрэгтэй ажиллаж, дадлагажна гэж бодож байна. Манай хамт олон их сайхан. Захирагчаасаа эхлээд энгийн ажилтан албан хаагч хүртлээ хүний төлөө сэтгэлтэй, зэмлэж бас хайрлаж чаддаг, эвсэг хамт олон. Тэднийхээ нэгэн эд эс нь болж, хүнтэй ажиллах чадвараас бага ч атугай суралцаж байгаадаа баяртай явдаг шүү. Миний ханийг Номин-Эрдэнэ гэдэг, бид П.Цэцэнгоо гэдэг хөөрхөн охинтой. Эхнэр маань Өмнөговь аймгийн Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд бага ангийн багш хийдэг. Ойрын төлөвлөгөөнд энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтэй яваа.



## ЭХ ОРНОО ТҮШСЭН ХҮН АЛДДАГҮЙ ЮМ ГЭЖ ААВ МИНЬ ЗАХИСАН

Зэвсэгт засварын тасгийн захирагч, ахлах ахлагч Ч.БАТТУЛГА:

–Зэвсэгт хүчинд алба хаагаад 15 жил болж байна. 1973 оноос хойших 47 жилийн түүхийнх нь 15 жилийг нь хамтдаа бичилцэж байгаадаа баяртай явдаг даа. Аав минь “Миний хүү цэргийн албанд ор. Эх орноо түшсэн хүн хэзээ ч алдахгүй, цэргээ дагасан хүн үргэлж сайн сайхан явдаг юм” гэсэн нь амьдралын минь зөв зам байсан шүү. Уг нь би Увс аймгийнх. Одоо бол Өмнөговь аймаг, тэр дундаа Зэвсэгт хүчний 167 дугаар анги миний төрсөн гэр мэт л санагддаг. Өмнөговь аймагаасаа хань ижилтэй болж, өнөр өтгөн айл болсон доо. Монголын сайхан эх орноо, ард түмнээ айх аюулгүй, амар жимэр амьдруулах энэхүү эрхэм агаад хариуцлагатай үүргийг мянга мянган жил монгол цэрэг нуруундаа үүрч, өнөөгийн бидэнд буухиалан хүргэсэн. Энэхүү дайчин уламжлалыг ангийнхаа бие бүрэлдэхүүний хамт түүчээлэн яваадаа баяртай байдаг шүү. Зэвсэгт засварлах нь миний хамгийн дуртай ажил.



## ЭНЭ АНГИ МИНИЙ ХОЁР ДАХЬ ГЭР

Барилга, орон сууцны нярав Т.ЗУЛЗАГА:


–Цэргийн амьдралаар амьдарч яваа он жилүүд миний хамгийн сайхан дурсамжуудын маань нэг. Өглөө бүр Төрийн дууллаа сонсоход ажилдаа шамдах хүсэл зориг минь илүү ихээр бадардаг юм. Манай анги миний амьдралын салшгүй нэг хэсэг юм. Өглөө бүр ангийнхаа хаалгаар орж ирэхэд гэр шиг минь их дотно мэдрэмж төрдөг. Бүх орчин нь дэндүү дотно. Алба хааж байгаа 13 жилийн хугацаанд цөөнгүй захирагчтай хамтран ажилласан. Бүгдээрээ л мундаг дарга нар байсан. Манай анги хэзээнээсээ халуун дулаан уур амьсгалтай, хамт олон нь эв нэгдэлтэй, нэгэндээ дэмтэй, атгасан гар шиг хүмүүс. Миний ханийг Д.Сайнжаргал гэдэг, бид хоёр хүүхэдтэй. Хүүхдүүд маань тусдаа гарч, амьдрал зохиосон. Хань минь мужаанаар ажилладаг ба “Танай ангид мужаанаар хийлгэх ажил байвал хэлээрэй. Очоод цааргалахгүй хийгээд л өгнө. Хань минь ажил миний л ажил гэсэн үг” гэж хэлдэг юм. Энэ нь гэр бүлээрээ л цэрэг, армидаа хайртай болсны маань шинж байх аа. Удахгүй барилгуудаа засварлаж шинэчлээд илүү тохитой орчинд ажиллах болсондоо баяртай яваа шүү. Зэвсэгт хүчинд мөр зэрэгцэн алба хааж байгаа генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчдаа өмнийн говиос мэнд хүргэе.



## НЭГ НУТГИЙН ГУРАВ

Дараагийн онцлох алба хаагчид бол дэд түрүүч Д.Эрдэнэтүлга, Н.Жамбалцанжид, байлдагч Д.Мөнх-Эрдэнэ нар. Тэд гурвуулаа Дундговь аймгийнх. Д.Эрдэнэтүлга Дэлгэрхангай, Н.Жамбалцанжид Сайнцагаан, Д.Мөнх-Эрдэнэ Эрдэнэдалай сумынх ажээ. “Цэрэгт ирээд ямар байна вэ” гэхэд бүгдээрээ л дуу нэгтэй “Сайхан” гэж хариулав. Дэд түрүүч Д.Эрдэнэтүлга “Цэрэг миний төсөөлж байснаас ч гоё юм байна. Анх хөл, гараа нийлүүлж чадахгүй будилуу явснаа бодохоор инээд хүрдэг шүү. Хөл нийлүүлээд цэргийн ёслолын жагсаалаар алхах хамгийн гоё. Биднийг өдий зэрэгтэй болгож сургаж байгаа ротын захирагч, ахлах дэслэгч Ц.Сэргэлэнбаатар даргадаа баярлаж явдаг даа. Ахын ёсоор зэмлэнэ, даргын ёсоор ч зааж зааварладаг. “Та нар нэг жилийн хугацааг хамгийн үр бүтээлтэй өнгөрүүлэх хэрэгтэй” гээд чөлөөт цагаараа ч өөрийгөө хөгжүүл гэдэг юм. Би дарга нарынхаа итгэлийг зүтгэлээр хариулах юм сан гэж хичээж явдаг даа. Хайртай ээж Ю.Батдэлгэртээ “Хүү нь албаа нэр төртэй хааж байгаа шүү. Цэргийн албанаас их зүйл сурлаа” гэдгийг цэргийн сониноор дамжуулан хүргэе” гэлээ.

Харин дэд түрүүч Н.Жамбалцанжид “Цэрэгт ирэхээсээ өмнө Говьсүмбэр аймгийн Политехникийн коллежид суралцаж төгссөн. Цэргийн алба намайг үг дааж хатуужуулсан, үүрэг хүлээлгэж сургасан. Үг даахгүй хүн уул даахгүй гэж үг байдаг даа. Энэ их үнэн үг юм билээ. Үг дааж байж, ажил даана. Аав Х.Нямдорж, ээж С.Уранчимэг нар Цэргийн тангаргийн баяраар ирээд “Ямар сайхан чийрэг харагдаж байна вэ?” гээд магтаад л байсан” гэв. Байлдагч Д.Мөнх-Эрдэнийн хувьд дуулах авьяастай гэнэ. Сум, орон нутгийнхаа тайзан дээр зөндөө гарсан, цаашдаа “Уяачид дуулж байна” уралдаанд оролцох хүсэлтэй. Цэргийн албыг өөрийн биеэр хааж байж эх орны тусгаар тогтнол, цэргийн алба хаагчдын ажил, үүргийг маш сайн ойлгодог юм байна. Одоо бодоход хугацаат цэргийн алба хаасан болон хаагаагүй залуус анддашгүй байдаг юм шиг ээ. Цэргийн алба хаасан залуусыг сагсуурч, эх оронч гэж өөрийгөө дөвийлгөж байгааг хараагүй. Төлөв томоотой, хүлээцтэй, сахилга, зохион байгуулалттай иргэн болон төлөвшсөн байдаг шүү.



# ХЯЗТААР НУТГИЙН ДАЙЧИД, ХОРОО ЦЭРГИЙН АДУУЧИД

Сүхбаатар аймгаас 2019 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдаж, Зэвсэгт хүчний 327 дугаар ангид алба хааж байгаа дайчидтай уулзлаа. Тэд бүгд тал нутагт морины зоон дээр өссөн адуучин залуус юм.

## ААВ ШИГЭЭ АЛДАРТАЙ МАЛЧИН БОЛНО



### Байлдагч Ц.БАТМӨНХ:

-Би Сүхбаатар аймгийн Халзан сумаас татагдсан. Миний нутаг удамт хурдан хүлгээрээ аймагтаа төдийгүй улсдаа алдартай. Аав, ээж маань малчин хүмүүс. Би дөрвөн хүүхэдтэй айлын отгон нь. Аавыг маань Ц.Цогтсүрэн гэдэг бөгөөд бид бод, бог нийлсэн 400 гаруй малтай. Жилийн дөрвөн улиралд нутагтаа оторлон малаа маллаж амьдардаг бидний хувьд өдөр хоногийг маш завгүй өнгөрүүлдэг. Малчин хүний амьдрал тийм л байдаг. Би бага байхаасаа аавтайгаа адуунд хамт явдаг байсан учир адууг арчлах, маллах талаар багагүй

мэдлэгтэй. Тиймдээ ч ангийн зусланд томилогдсон. Дорнодын талд адуу маллах сайхан юм. Энд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сууриас татаж авчирсан нэлээд адуу бий бөгөөд ангийн ойролцоо тэдгээрийг бэлчээж, уналгад бэлтгэхээс гадна саамыг нь хурааж, айраг эсгэдэг. Миний хувьд эмнэг үрээ, байдас сургаж, уналгад бэлэн болгож байна. Бид энд гараад сар гаруй хугацааг өнгөрүүлж байгаа бөгөөд намар эндээс бууж, адуугаа ангийн суурьт эргүүлэн тавина.

Эргэж очоод нутагтаа малаа маллана. Ирээдүйд аав шигээ нутаг орондоо алдартай сайн малчин болно гэж боддог.

## ОФИЦЕР БОЛНО ГЭСЭН ЗОРИЛГООСОО УХРАХГҮЙ



### Байлдагч Э.САНЖИЙДОРЖ

-Манайх Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд нутагладаг. Манай сум улаан ямаагаараа улсдаа алдартай. Мөн Хашаат, Наран, Сайн гэх мэт олон булаг, рашаантай. Ер нь булаг, шанд ихтэй сайхан нутаг даа. Миний аав сумынхаа уугуул малчин бөгөөд 70 гаруй адуу, 100 гаруй бог, 20 гаруй үхэртэй. Би айлын отгон хүүхэд. Дунд ах Үндэсний биеийн тамирын дээд сургуулийг төгсөөд сургуульдаа үргэлжлүүлэн багшилж байгаад цэргийн албанд татагдаад одоо Хилийн цэргийн 0132 дугаар ангид алба хааж байна. Харин том ах 2009 онд цэргийн алба хаасан бөгөөд одоо нутагтаа ямаан сүргээрээ алдартай малчин болсон. Аав маань ах нарыг бага байхад "Та нар эрчүүд, ирээдүйд айлын эцэг хүн

болно. Тиймээс заавал цэргийн алба хааж, олон эрчүүдийн дунд орж, тэдэнтэй нөхөрлөж, хүний үгийг дааж, тэсвэр хатуужилтай болох хэрэгтэй" гэж хэлдэг байсан. Аавынхаа сургаал, зөвлөгөөг бид гурвуулаа биелүүлж яваадаа баяртай байна.

Цэргээс халагдаад ҮБХИС-д суралцана гэж төлөвлөсөн. Өмнө нь "Их засаг" их сургуулийн эрх зүйн ангид сар гаруй хугацаанд суралцаж байгаад ҮБХИС-д суралцах шалтгаанаар сургуулиасаа гарсан боловч сонсогч болж чадаагүй. Ядаж цэргийн алба хаачивал сургуульд нь суралцахад дөхөм байх болов уу гэж бодсон юм. Ямартаа ч ҮБХИС-д суралцаж, офицер болно гэсэн зорилгоосоо ухрахгүй.

## ЦЭРГИЙН НӨХӨРЛӨЛ ХАМГИЙН БАТ БӨХ ГЭЖ БОДДОГ

### Байлдагч Г.ЧУЛУУНБААТАР:

-Би Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт төрсөн. Миний аавыг Т.Гансүх, ээжийг Я.Батцэцэг гэдэг бөгөөд би айлын ууган хүүхэд. Гэр бүлийнхэн маань сумын хойд нутгаар мал маллаж амьдардаг. Манайх дөрвөн азарга адуу, 100 гаруй хоньтой. Багаасаа мал маллаж, адуутай ноцолдож өссөн болохоор ангийнхаа зусланд адуу хариулж, эмнэг сургах нь надад тун ч сайхан байна.

Хот, суурин газраас хол хөндий хөдөө өссөн миний хувьд цэрэгт ирээд их зүйлийг сурч мэдсэн. Олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцээд тэдэнтэйгээ хамт нэгэн үзүүрт сэтгэлээр бэрхшээл бүрийг хамтдаа давж байгаа болохоор цэргийн нөхөрлөл хамгийн бат бөх гэж би боддог. Нутагтаа очоод аав, ээждээ тусалж, малаа маллана. Миний нутаг



чинь Дарьганга, Шилийн богд, Оргихын булаг, Талын агуй, Ганга нуур гээд л монгол түмний бахархал болсон үзэсгэлэнт газруудын өлгий болсон сайхан газар даа.

## АЛБА ХААХААР ШИЙДЭХЭД ЭХНЭР МААНЬ ЭХЭНДЭЭ ЗӨВШӨӨРӨӨГҮЙ

### Байлдагч Х.БАТ-ОРГИЛ:

-Манайх Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт аж төрдөг. Би эхнэр, хүүхдийн хамт хотод амьдардаг бөгөөд хүү маань одоо нэг ой дөрвөн сартай. Эхнэр "Их засаг" их сургуулийн дөрөвдүгээр дамжааны оюутан. Харин би 2015 онд "Этүгэн" их сургуульд элсэж татварын эдийн засагч мэргэжлээр энэ хавар төгссөн юм. Хоёр сар гаруй хугацаанд мэргэжлээрээ хувийн компанид ажиллаж байгаад цэргийн албанд татагдсан. Цаашдаа төрийн байгууллагад ажиллах зорилготой учир цэргийн алба хаахаар шийдсэн минь энэ. Харин энэ ангийг сонгосон учир нь манай уугуул нутгийн найзууд өмнө нь энэ ангид цэргийн алба хаасан учир тэднийхээ зөвлөгөөг дагасан гэх үү дээ.

Оюутны ширээнээс холдоод удаагүй байсан миний хувьд эхэндээ цэргийн албаны онцлог, орчин нөхцөл, сургалт, дадлага гээд бүх зүйл нь содон санагдаж, шантарч, бууж өгөх ч үе байлаа. Тэгэх бүрд өөрийгөө хурцалж, "Надтай адилхан аавын хөвгүүд чадаад байхад би гар, хөл бүтэн эрүүл саруул байж яагаад чадаж болохгүй гэж" өөртөө хэлдэг байсан. "Онжавууд" маань ч надад хэцүү



үед үргэлж тусалж, ёстой л "Дэм дэмэндээ, дээс эрчиндээ" гэх ардын зүйр үг шиг байж чадсан учир би бүх зүйлийг даваад гарсан. Одоо цэргийн албандаа дасаад гүйлт, биеийн тамираараа манлайлагчдын эгнээнд ортлоо өөрчлөгдсөн байна.

Анх цэрэгт алба хаахаар шийдэхэд эхнэр маань маш

дургүй хүлээж авсан. Орхиж явах гэлээ, тэгээд бүр явах явахдаа Дорнод аймаг руу алба хаахаар явдаг нь ямар учиртай юм гээд их л уурласан. Харин одоо намайг хэрхэн өөрчлөгдөж, хөгжсөнийг хараад миний сонголтыг хүндэтгэх болсон. Цэргээс халагдаад мэргэжлээрээ ажиллана даа.

## "ОНЖАВУУД"-ТАЙГАА ҮРГЭЛЖ ХОЛБООТОЙ БАЙХ БОЛНО



### Байлдагч М.ЭРДЭНЭХҮҮ:

-Би Сүхбаатар аймгийн Наран сумаас цэрэгт татагдсан. Айлын отгон хүү, хоёр эгчтэй. Цэрэгт ирсэн шалтгаан гэвэл олон эрчүүдтэй нөхөрлөж,

үеийн залуусын дунд өөрийгөө бие бялдар, оюун ухаан гээд бүхий л зүйлээрээ ямар түвшинд байгаагаа мэдэхийг хүссэн. Тиймээс цэргийн албанд өөрийн хүсэлтээр татагдсан.

Дунд сургуулиа төгссөн эхний жилд цэргийн зарлан дуудах хуудас ирэхэд нь тэр даруй "чавхдаад" яваад очсон, тэнцсэн. Гэтэл аав маань надад "Мал дээр эр хүн хэрэгтэй байна. Чи бид хоёроос өөр хүн байхгүй учир эндээ бай" гэж хэлсэн. Зөвлөгөөг нь ч дагасан. Харин дараа жил нь заавал явна гэж өөртөө амласан учир шууд цэрэг татлагын байранд очиж тэнцчихээд гэрийнхэндээ хэлсэн.

Дарга нар намайг адуу, малтай ойр өссөн учир ангийн зусланд үүрэг гүйцэтгүүлэхээр сонгосон. Энд ирээд унага татаж, гүү барьж сурч байна даа. Манай нутагт гүү барьдаггүй. Цэргийн албанд ирээд хүнээс үг сонсож сурч, тэсвэр хатуужил сууж байна. Мөн зэвсэглэл, техник хариуцан, ашиглаж сурч байна гээд тоочоод байвал аливаа хүнийг жинхэнэ эр хүн болгодог олон чанарт суралцаж байна даа.

Хэрвээ би цэрэгт яваагүй бол ийм олон найз нөхөдтэй болохгүй байсан. Нутагтаа эргэж очоод "онжавууд"-тайгаа үргэлж холбоотой байх болно. Бид ирээдүйд олон жил нөхөрлөнө.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

# ДОЛОННУУР-ЖЭХЭГИЙН ЧИГЛЭЛИЙН БАЙЛДААН ...

**ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Орчин үе, бүс нутгийн салбарын эрхлэгч доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа Галиндэвийн МЯГМАРСАМБУУ**

Энэ чиглэлд давшсан МАХЦ-ийн 5 дугаар морьт дивизийг хошууч генерал Ч.Доржпалам, 6 дугаар морьт дивизийг хурандаа М.Цэдэндаш, 7 дугаар морьт дивизийг хурандаа Г.Дорж, 8 дугаар морьт дивизийг дэд хурандаа М.Одсүрэн, танкийн 3 дугаар хороог хошууч З.Дагвадорж, 9 дүгээр бэлтгэл морьт хороог хурандаа С.Галсан, холбооны тусгай хороог хошууч Дагва нар командалжээ. Мөн хошууч генерал Ч.Мижид, штабын дарга В.Даржаа нарын удирдсан Ардын Өөрийгөө Хамгаалах Сайн Дурын Морьт Отряд хоёр хэсэг болон энэ чиглэлд байлдааны үүрэг гүйцэтгэв.

Долоннуур, Жэхэгийн чиглэлд Зөвлөлтийн Армийн хурандаа В.И.Иванушкиний командалсан танкийн 43 дугаар бригад, хурандаа В.П.Поповын командалсан 25 дугаар механикжуулсан бригад, хошууч генерал Л.Е.Коркуцкийн удирдсан 59 дүгээр морьт дивиз, гвардийн хурандаа Б.М.Даденкогийн удирдсан танк эсэргүүцэх 35 дугаар их бууны бригад, хурандаа Чернамазийн командалсан 60 дугаар гвардын миномётын хороо, хошууч Бакаев захирагчтай 1914 дүгээр зенитийн их бууны хороо, хошууч Д.И.Шматков даргатай зенитийн их бууны 1917 дугаар хороо болон 293 дугаар моторжуулсан инженерийн батальон, 907 дугаар холбооны батальон оролцжээ.

Байлдааны энэхүү чиглэлд Японы цэргийн 108 дугаар явган дивиз, 8 дугаар явган бригад, хамгаалалтын отряд, Манжийн 2, 4, 5, 6, 25 дугаар явган бригад, хоёр холимог бригад байсан бөгөөд тэдгээрт 57674 хүн, 35205 винтов, 1372 хүнд, хөнгөн пулемёт, 395 гранатомёт болон төрөл бүрийн калибрын их буу 186, танк 169 байв. Үндсэн бүлэглэл нь Долоннуурын районд танкийн бригад 1, явган бригад 1, Жэхэгийн районд явган дивиз 1, холимог бригад 1, хамгаалах отряд 1 байрлаж байв.

Монгол, Зөвлөлтийн цэргийн анги, салбарууд 1945 оны 8 дугаар сарын 9-ний өглөө 04.00 цагт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийг давж, хоёр цувраа болон давшилтад оржээ. Давшилтын эхний өдөр нэгдүгээр цуврааны техникжсэн ангиуд 70 километр, хоёрдугаар цуврааны морьт нэгтгэлүүд 35-60 километр давшиж, Шеншингийн овоо, Тайпуу усны худгийн районуыг эзэлжээ. Япон, Манжийн хилийн застав, тагнуулын анги, салбарууд Монгол, Зөвлөлтийн цэргийг эсэргүүцэн байлдалгүй өмнө зүгт зугтсан байна.

Морьт механикжуулсан бүлгийн анги, салбарууд давшилтаа эрчимжүүлж, 8 дугаар сарын 11-ний өдөр Шанага, Бага Тоуха, 8 дугаар сарын 12-ны өдөр Ар цагаан нуур мөн сарын 13-ны өдөр Яндуу сүм, Тас овооны заагийг эзэлжээ.

Долоннуур, Жэхэ хотыг чөлөөлөн, цааш давшиж Жанбэй, Хаалганы бэхлэсэн районуыг эзлэх тушаалыг Өвөр Байгалийн фронт командлагч 8 дугаар сарын 13-ны өдөр Монгол, Зөвлөлтийн цэргийн морьт механикжуулсан бүлгийн командлалд өгчээ. Тус бүлгийн анги, нэгтгэлүүд өдөрт 90-100 километр давшиж байсан боловч Ар цагаан нуураас цааш 150 гаруй километр үргэлжилсэн Цахарын элсэн цөлийг гатлахад хуягт танк, их буу болон ар талын ангиудын давшилтын хурд саарч зарим үед цагт таван километрээс хэтрэхгүй байв. Мөн шатахууны нөөц дуусаж техникийн анги, салбарууд нь үндсэндээ байлдааны үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон бөгөөд зөвхөн морьт ангиуд маршийг байгаль, цаг агаарын хүнд нөхцөлд тасралтгүй үргэлжлүүлж байжээ.

Өвөр Байгалийн фронтын командлагчаас ангиудын маршийг хурдасгаж морьт ангиудыг 8 дугаар сарын 15-ны орой гэхэд Долоннуурын районд хүрсэн байх

захирамжийг 8 дугаар сарын 12-ны өдөр өгсөн байна. Гэтэл Долоннуур хүртэл 300 шахам километр зайтай байсан бөгөөд Монгол, Зөвлөлтийн нэгтгэл, ангиуд туулахад нэн бэрх, үсгүй их элсэн цөлд тулж ирээд



Жэхэ хотыг чөлөөлсөн нь

байв. Тиймээс армийн генерал И.А.Плиев нэгтгэл, ангиудын дарга нарыг дуудан шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулжээ. Энэ тухай С.Равданы дурсамжид "Нэг хоног явсны дараа Баянхүрээ нуурын орчим Цахарын элсний хойд захад түр бууж амрав. Энэ үеэр Плиев дивизийн бүх дарга нарын зөвлөгөөнийг хийв. Үүнд, Ж.Лхагвасүрэн, Ю.Цэдэнбал нар оролцсон ба генерал И.А.Плиев буугаа ширээн дээр гаргаж тавьчаад маш ууртай байсан, маш сүртэй зөвлөгөөн болсон" хэмээн бичжээ. Мөн Жанжин штабын чиглэл хариуцсан офицер, хурандаа Д.Гомбожавын дуртгалд "Ар Цагаан нуурт манай ангиуд хүрэлцэн очоод байхад Плиев нэгтгэл, ангиудын явж ирсэн дүнг гаргаад их элсийг хэрхэн гатлах, Долоннуур хотыг эзлэн авах төлөвлөгөөгөө танилцуулав. Хятадын Цагаан хэрэм хүрэхийн тулд Плиев өөрөө 7 дугаар дивизийг Жэхэ хүргэх, Ю.Цэдэнбал дарга, хошууч генерал С.Равдан нар 8 дугаар дивизийг, генерал Ж.Лхагвасүрэн 5 дугаар дивизийг, генерал Д.Дамдинхүү 6 дугаар дивизийг заасан газарт хүргэх үүрэг авцгаасан билээ" хэмээн бичсэн байдаг.

Групп командлан захирагч, хурандаа генерал И.А.Плиев фронт командлагчийн тушаалын дагуу Долоннуур хотыг заасан хугацаанд нь эзлэн авахын тулд давшилтын хурдыг нэмж, хөдөлгөөнт механикжуулсан бүлгийг байгуулан өөрөө тэрхүү бүлгийг удирджээ. Харин МАХЦ-ийн удирдах дарга нар тус тусын хуваарьт дивизүүд дээр ажиллаж давшилтыг удирдах болов. Энэ тухай хошууч генерал С.Равданы дурсамжид, "Ингээд Улс төрийн газарт 8 дугаар дивизийг түргэлүүлэх үүрэг хариуцуулав. Цэдэнбал энэ үүргийг надад өгөөд командлагчийн хамт Долоннуурын зүг хөдлөв. Би Баянхүрээ нуурын дэргэдээс буцаж Яндуу сүмийг дайрч Сэнсний хийдээр ороод Зүүн Сөнөдийн Богд уулыг хүртэл элсэн манхан дундуур явж, дивизийн хоцорсон ар тал, машин, техникийг түргэн урагшлуулах шаардлага тавьсан боловч хэний ар тал, хэний цэрэг, хэний машин яваа нь мэдэгдэх аргагүй холилдон байв. Тээврийн ба хуягт машинуудын бензин дуусаж, бөөн бөөнөөрөө суусан буюу морьтой, тэрэгтэй, арав хориороо цувсан цэргүүд, тэмээн тэрэг, их буу зэргийг хэсэг бүлгээр нь бөөгнүүлж хөдөлгөөд буцсан билээ" гэжээ.

Монгол, Зөвлөлтийн цэргийн морьт ангиуд 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хурдавчилсан маршид шилжиж Тэнгэр элсийг гатлав. Их элсэн цөлийг гатлах үед аагим халуун нар бие, сэтгэл хоёрыг давхар төөнөж, тэсэхүйеэ бэрх байсан учраас цэргүүд олноороо наранд

цохиулан жагсаалаас гарах аюул тулгарч, машин техникийн моторууд халж, радиаторын ус нь ууршиж байхад "Ус гэдэг алтнаас үнэтэй нутаг байдаг ажээ" хэмээн бодож явсан тухайгаа И.А.Плиев

урсгалт гол мөрөн олшрон бартаа саад ихтэй болохын зэрэгцээгээр олон хоног үргэлжилсэн бороо орж байсан нь давшилтад ихээхэн хүндрэл учруулж байв. Энэ тухай И.А.Плиев "Бид эхлээд Шаньдүхэ,

нь дайран орж бууж өгөхийг тулган шаардсанаар дайсны 700 орчим дарга, цэргийг олзолж, зэвсгийг нь хураан авав. Японы цэргийн олон хүнтэй гарнизоныг ийнхүү буулган авсны үр дүнд Луньхуа хотыг төвөггүй эзэлсэн байна. Түүнчлэн Б.Таяагийн удирдсан тагнуулчид Жэхэ хот руу ухарч байсан дайсны томоохон бүлэглэлийг илрүүлсэн бөгөөд 8 дугаар морьт дивизийн 22, 34 дүгээр морьт хороо хоёр талаас нь гэнэдүүлэн дайрч 172 дарга, цэрэг болон буу зэвсгийг олзлов. Ийм жишээ олныг дурдаж болно.

Монгол, Зөвлөлтийн цэргүүд 8 дугаар сарын 18-ны шөнө Жэхэд хүрч, тус хотод хориглож байсан Японы цэргийн гарнизоныг буулган авч, Япон, Манжийн 8000 гаруй дарга, цэрэг болон 9126 винтов, 123 пулемёт, 15 миномёт, 6 их буу, 3 хөнгөн танк, 900 автомашин, 42 агуулах бүхий зэвсэг хэрэгслийг олзлон авчээ.

Жэхэ хот эзлэгдсэнээр япончууд хойд Хятад дахь бэлтгэл хүчнээсээ таслагдаж, Өвөр Байгалийн фронтын гол хүчний баруун жигүүр аюулгүй болов. Жэхэ хотыг эзэлсний дараа Морьт механикжуулсан бүлгийн нэгтгэл, ангиуд давшилтаа Бээжин хотын зүг чиглүүлэв. Долоннуур-Жэхэгийн чиглэл дэх дайсны сүүлчийн томоохон түшиц газар нь Цагаан хэрэмтэй хаяа дэрлэн оршиж, өндөр уулсаар хүрээлэгдсэн Губэйкоу хот байв. Хятадын төмөр замын зангилаа газар болох энэ хотод Японы Эзэн хааны 8 дугаар корпусын штабын дарга, дэд хурандаа Очигийн командалсан 31, 35 дугаар тусгай отряд, 76 мм-ийн их бууны батареи, 45 мм-ийн танк эсэргүүцэх их бууны батареи, миномётын батареи бүхий хүч байрлаж байжээ. Морьт механикжуулсан бүлгийн анги, салбарууд 8 дугаар сарын 21-ний өдөр Губэйкоу хотыг эзэлж Японы 1300 орчим дарга, цэрэг болон үлэмж хэмжээний буу, зэвсгийг олзолсон байна.

Ийнхүү Долоннуур-Жэхэгийн чиглэлд давшсан Монгол, Зөвлөлтийн нэгтгэл, ангиуд байгаль, цаг агаарын хүнд нөхцөлд давшиж, дайсны хүчтэй эсэргүүцлийг амжилттай няцаасаар 1000 гаруй километр хол газрыг 9-10 хоногийн дотор туулж, байлдааны үүргээ биелүүллээ. Монгол-Зөвлөлтийн дайчид аагим халуун, аадар борооны дундуур их элсэн цөл, өндөр уул даваа, өргөн гол мөрнийг гатлан давшиж, тэсвэр тэвчээр, зориг хатуужлын үлгэр жишээг үзүүлсэн юм. Давших операц дууссаны дараа МАХЦ-ийн 5 дугаар морьт дивиз Губэйкоу хотод, 6 дугаар морьт дивиз Бикши, 7 дугаар дивиз Жэхэ, 8 дугаар морьт дивиз Луаньпин хотод тус тус түр байрлаж юуны түрүүнд ард

дурсан бичсэн байдаг нь Монгол, Зөвлөлтийн цэргийн давшилт ямар хүнд нөхцөлд явагдсаныг гэрчилнэ.

Монгол, Зөвлөлтийн морьт ангиуд Баянхүрээ нуураас цааш өдөрт 90-100 километрийн хурдтай давшигдаа ар талаасаа тасарч, хоол үндгүй, амралтгүй явж, элсэнд суусан машин тэрэг, их буу, техникээ татаж гаргах 15-20 хүнтэй командыг байгуулан хүн, морь, тэмээ гурвын хүчээр машин техникээ татаж гаргасаар явжээ. Үүний үр дүнд түрүүчийн ангиуд нь 8 дугаар сарын 16-ны орой Долоннуур хотыг эзэлж, ар талын болон техникийн ангиудыг татаж аван хүчээ хуралдуулах арга хэмжээ авсан байна.

Давшилтын үед нэгтгэл, ангиудтай байнгын холбоо барих үүргийг МАХЦ-ийн Жанжин штаб дээр 3 дугаар хэлтсийн дарга, хошууч Нацагдорж гүйцэтгэж, байлдааны мэдээг Цэргийн Явдлын Яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсан, Жанжин штабын дарга, дэслэгч генерал И.Г.Рубин нарт дамжуулж байв. Мөн Долоннуур, Жэхэ, Бандид гэгээний хийдийн районд радио буудал байгуулан холбоо барьж байснаас гадна Улаанбаатар, Долоннуур, Жэхэ, Хаалганы чиглэлд цэргийн шуудангийн 34 машин долоо хоног тутамд явж байв. Өвөр Байгалийн фронтын штаб болон Хаалган, Манжуурын чиглэлийн зэргэлдээ

дараа нь Луаньхэ мөрний хөндийг даган Майшань, Пукэлин хоёр нурууны хоорондуур урагшилсан учир тэнгэрээс, хоёр хажуугийн уулнаас ийм гурван талаас ус бууж, гол мөрөн халин үерлэж, хилэгнэж галзуурсан өргөн урсгал нь юм бүхнийг хаман урсгаж байв ... Үе үе тэнгэр нижигнэн, цахилгаан цахилж, харанхуй тэнгэрт гэрэлт шугам татна. Байгаль дэлхий үнэхээр галзуурчээ. Тэнгэрээс үл мэдэгдэх нэн аймшигт хүчин бууж ирэх шиг санагдана" хэмээн бичжээ.

Монгол, Зөвлөлтийн цэргийн ангиуд 8 дугаар сарын 16-ны өдөр Долоннуурын районоос хоёр чиглэлээр хүч хуваарилан давшив. Баруун замын Иншан, Чунэлиний уул нуруу бүхий газраар Фыннин, Жэхэ хотын чиглэлд Зөвлөлтийн 59 дүгээр морьт дивиз, МАХЦ-ийн 5, 7 дугаар морьт дивиз, зүүн талаар нь МАХЦ-ийн 8 дугаар морьт дивиз давшин байлдаж, 8 дугаар сарын 17-ны өдөр Фыннин, 20-ны өдөр Луаньпин хотыг эзэлжээ.

Монгол цэргүүд байгалийн саад бэрхшээлийг даван туулж, дайсны эсэргүүцлийг няцаан, байлдааны үүргээ нэр төртэй биелүүлж, эрэлхэг зоригтой тулалдаж байв. Тухайлбал, хошууч Б.Сүрэнхорлоогийн командалсан МАХЦ-ийн 8 дугаар морьт дивизийн 34 дүгээр морьт хороо Шаохунзы тосгонд хориглосон дайсныг



Губэйкоу хотыг чөлөөлсний дараа цуглаан хийж байгаа нь

ангиудтай радио ба цахилгаан мэдээ, нисэх онгоц, газрын шуудангаар тасралтгүй холбоо барьж байжээ.

Байлдааны дараагийн үүрэг нь дайсны стратегийн чухал зангилаа болсон Жэхэ хотыг чөлөөлөх явдал байв. Долоннуураас цааш Их Хянган, Иншаны уул нуруу үргэлжилсэн учраас давшилтын замд өндөр уул даваа, хад хавцал, түргэн

бүсэлж, 90 шахам дарга, цэргийг зэвсгийнх нь хамт олзлов. Ахмад Б.Таяагийн удирдсан 22 дугаар морьт хорооны тагнуулын бүлэг 8 дугаар сарын 20-ны шөнө Луньхуа хотын дэргэд Японы цэргийн ангийг бүслэн авчээ. Ахмад Б.Таяа, салааны дарга, бага дэслэгч Дэмбэрэл, хөнгөн пулемётчин Дэмчиг, мэргэн буудагч, байлдагч Чойжамц, Дашзэвгэ нар дайсны харуулын цэргийг устгаад штабт

хоцорсон хүн, зэвсэг, техник, ар талаа татаж авах, бие бүрэлдэхүүн, агт морьдоо амраахын хамт тус тусын хотоо хамгаалан харуул манаа гаргаж, байлдааны ба улс төрийн бэлтгэл сургууль хийж байв.

**Долоннуур, Жэхэгийн чиглэлийн давшиж байлдаан нь XX зууны монгол цэргийн түүхэн дэх хамгийн хүнд бэрх давшилтад зүй ёсоор тооцогдоно.**

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙН САН ХӨМРӨГИЙН ДЭЭЖСЭЭС

# ЦЭРГИЙН ЯВДЛЫН ЯАМНЫ ИХ БУУНЫ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ ГЭНДЭНГИЙН РЭНДОО

1945 оны Чөлөөлөх дайны ялалтын баярын 75 жилийн ойг тохиолдуулан Цэргийн явдлын яамны Их бууны газрын дарга, хошууч генерал Гэндэнгийн Рэндоогийн тус дайны түүхэнд холбогдох соёлын өвийн дээжээс уншигч та бүхэндээ толилуулж байна.

Г.Рэндоо БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны 1943 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн тушаалаар Бригад командлан захирагч цол, БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Их бууны хошууч генерал хэмээх анхны цолыг хүртсэн Монгол Улсын анхдагч 11 генералын нэг юм.

## НАМТРЫН ТОВЧООН

Хошууч генерал Г.Рэндоо нь 1906 онд Засагт хан аймгийн Засагт ханы хошуу, одоогийн Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт төрсөн.

Тэр бээр 1923 онд цэргийн албанд татагдан ирж Ховдын 4 дүгээр морьт хороонд цэрэг, бага дарга, 1925-1928 онд ЦЕС-ийн их бууны анги, 1928-1932 онд ЗХУ-д Тверийн морин цэргийн ба их бууны дунд сургууль, 1932 онд тусгай отрядын их бууны батарейн дарга, 1932-1933 онд Улаанбаатар хот дахь Их бууны хорооны штабын дарга, 1933-1935 онд Тамсагбулаг дахь 6 дугаар морьт дивизийн Их бууны хорооны штабын дарга, 1935-1938 онд мөн хорооны дарга, 1938-1939 онд Цэргийн ерөнхий сургуулийн Их бууны дивизионы дарга, тус сургуулийн штабын дарга, 1939 оноос МАХЦ-ийн Жанжин штабын орлогч дарга бөгөөд байлдааны бэлтгэлийн хэлтсийн дарга, 1940-1948 онд Бүх цэргийн Их бууны газрын дарга, 1948-1949 онд ЗХУ-д Их бууны дээд дарга нарын курс, 1949-1953 онд Улсыг батлан хамгаалах яамны Их бууны газрын даргаар ажиллаж байгаад тус газар татан буугдсан учир цэргийн албанаас бэлтгэлээр халагджээ.


Г.Рэндоо нь 1932 онд баруун аймгуудад дэгдсэн зэвсэгт бослогыг дарах, 1936 онд зүүн хязгаар Булан дэрс, Адаг дулаанаар халдан довтолсон Япон, Манжийн цэргийн өдөөн хатгалгыг няцааж цохих байлдаанд их бууны анги, салбаруудыг командлан амжилттай оролцсон юм. Түүнчлэн 1939 оны Халхын голын дайнд МАХЦ-ийн хээрийн штабын бүрэлдэхүүнд ажиллахын хамт Матадын 8 дугаар морьт дивизийг сар гаруй хугацаанд командлан ерөнхий давшилтад оролцжээ. 1945 оны Чөлөөлөх дайнд МАХЦ-ийн нэгтгэл, ангиудын байлдааны ажиллагааг зохицуулах Жанжин штабын төлөөлөгчөөр Чуулалт хаалга-Жанчхүүгийн давааны чиглэлд амжилттай ажилласан ба 1947-1948 онд баруун хязгаарт Оспаны дээрэмчдийн халдлагыг бут цохиход оролцсон Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн юм.

Хошууч генерал Г.Рэндоогийн эдэлж хэрэглэж байсан эд өлгийн 43 нэр төрлийн зүйлсийг түүний гэр бүл, үр хүүхдүүдээс Монгол Цэргийн музейн сан хөмрөгт 1990 онд хүлээлгэн өгснөөр

эдүгээ музейн байнгын үзүүлэлт, үзэсгэлэнд дэглэн үзэгч олны мэлмийг мялаан сурталчилж байна.


БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Монгол Ардын Хувьсгалт Цэргийн дарга нарыг нийтэд нь офицер хэмээн нэрлэхээр болж, цэргийн цолыг шинэчилсэн ажээ. Үүгээр маршал, генералуудын дүрэмт хувцсанд бүтэн, хагас эполет тэмдэг, офицеруудын шинель, цамцны мөрөнд погон (мөрдэс) зүүхээр болж, түүнд алт болон мөнгөн өнгийн давхар хошуутай, дан хагас үндэсний өлзий тэмдэг байхаар болжээ.

Генералын ёслолын сэлмийг 1944 онд ЗХУ-д Златоустын Зэвсгийн үйлдвэрт захиалгаар хийлгэсэн бөгөөд уг сэлмийн эх зургийг Төрийн шагналт зураач Д.Чойдог агсан зохиожээ. Уг сэлэм нь 94,4 сантиметр урттай, өргөн нь 3 сантиметр, зэвэрдэггүй гангаар



Генерал сэлэм 1944 он

хийсэн. Бариулын үзүүр ба уг нь алтадмал чимэгтэй түүний нэг тал дээр 1940 оны сүлдтэй, сэлэмний бариулаас урагш үнхэлбэрийн хэсэгт "МАХЦ-ийн генерал" гэж алтадмал дэвсгэр дээр бичжээ. Сэлэмний хуйг алтан шармал алхан хээ бүхий гурван ширхэг бүслүүрээр чимж, хоёр бүслүүрээс нь оосор зүүх



зориулалттай хоёр алтадмал гархийг тус тус бэхэлсэн байна.

## Г.РЭНДОО 1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД

Хошууч генерал Г.Рэндоо нь 1945 оны Чөлөөлөх дайнд Чуулалт хаалга-Жанчхүүгийн давааны чиглэлд давшан Өвөр Байгалийн фронтын Өмнөд бүлгийн бүрэлдэхүүнд орсон МАХЦ-ийн нэгтгэл, ангиудын байлдааны ажиллагааг удирдан зохион байгуулах дээд командлалын бие төлөөлөгчөөр амжилттай ажиллаж дайны ялалтад үнэтэй хувь нэмрээ оруулсан юм.



Тэрбээр 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон тухай өөрийн дурдатгалдаа "Намын Төв хороо, Засгийн газар, 1945 оны 5 дугаар сарын дунд үеэс авхуулаад Дорноговь,



бидэнтэй хамт давших болсон нь дайчин биднийг зоригжуулж байсан юм.

Монгол Ардын Хувьсгалт Цэргийн 7 дугаар хуягт бригадын дарга, хурандаа Д.Нянтайсүрэн, штабын дарга Шархүү, улс төрийн орлогч, хошууч Т.Санзай нар анги, салбараа зохион байгуулж, тэдний давшилтыг

Энэхүү одонгоор дараалуулан шагнуулсан цорын ганц гавьяатан бол хошууч генерал Г. Рэндоо юм. Тэрбээр 1933, 1939, 1945, 1949 онд уг одонгоор дараалан шагнагдаж байжээ.

Хошууч генерал Г.Рэндоогийн эх орныхоо өмнө байгуулсан гавьяа зүтгэлийг Төр, засгаас өндрөөр үнэлж



Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор дөрвөн удаа, Байлдааны гавьяаны одонгоор хоёр удаа, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, "Алтан гадас" одон болон бусад ойн медалиар шагнажээ. Мөн ЗХУ-ын Октябрийн хувьсгалын одон, Улаан тугийн одонгоор тус тус шагнагдсан нь эдүгээ Монгол цэргийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байна.

Монгол цэргийн музейн мэргэжлийн албаны дарга, Эрдэм шинжилгээний ажилтан А.ГАНГАНЧИМЭГ



Хошууч генерал Г.Рэндоогийн мундер 1944 он

# Б.Тэмүлүн: АМТААР ЦАГ ХУГАЦААНЫ АЯЛАЛ ХИЙЖ БОЛДОГ

"Sweet kitchen" групп 2011 онд үүссэн бөгөөд санаачилсан бөгөөд өдгөө 300 мянга гаруй гишүүдийг хамарсан, хамгийн том фэйсбүүк группүүдийн нэг болжээ. Группийн гишүүд хоорондоо хоолны жороо солилцож, бие биедээ зөвлөгөө өгөөд зогсохгүй, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгоход тусалж буй энэхүү группийг санаачлагч нь шавилхан биедээ багтахаргүй хүчирхэг нэгэн бүсгүй байдаг.



## Манай уншигчдад өөрийгөө танилцуулна уу?

-Намайг Батбумын Тэмүлүн гэдэг. МУИС-ийг ардын бүжиг, урлаг судлаачийн мэргэжлээр төгссөн. Дараа нь мэргэжлээрээ ажиллаад хүүхдүүдэд бүжгийн хичээл заадаг байсан. Удалгүй жирэмсний амралтаа авснаар өөрийн хоббигоо хөгжүүлж бялууны бизнест хөл тавин гурав дахь жилдээ ханцуй шамлан ажиллаж байна. Бүжиглэхээ болиод 10 гаруй жил өнгөрсөн ч чөлөөт цаг гарвал сургалт болон дугуйланд хичээллэхийг боддог.

## "Sweet kitchen" группийг анх ямар зорилготой нээсэн бэ?

-Би бялуу хийх их дуртай байсан. 2011 онд нярайлсныхаа дараа гэртээ янз бүрийн шинэ зүйлсийг туршиж үздэг байлаа. Ялангуяа, төрөл бүрийн хоолны жорыг. Тэр бүхнээ ээж, хүүхдийн асуудлыг хоорондоо зөвлөлддөг фэйсбүүкийн группэд нийтэлдэг байсан. Гэтэл тус группэд миний хоолны жор хэтэрхий "дали" байгааг анзаарсан учраас тусдаа групп үүсгэсэн. Гэнэт санаачилсан групп маань богино хугацаанд олон хүнд хүрч чадсан нь маш олзуурхуштай.

## Таны бялууны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэрхэн явагддаг вэ?

-Үйл ажиллагааны хувьд үйлдвэрийн цехтэй бөгөөд шат дамжлага болгон дээрээ хуваагдаж ажилладаг. Гурил бэлтгэх, кремний бэлтгэл, чимэглэлийн хэсэг, бялуу угсралтын хэсэг, хүргэлт, захиалга, агуулах, нярав гэсэн цөөн тооны дамжлагаар хийдэг.

### Захиалга хэр ирдэг вэ?

-Үйлдвэрийн ачаалал бага учир боломжит хэмжээгээрээ авдаг. Захиалгын тоогоороо л үйлдвэрлэдэг учраас хуучин бүтээгдэхүүн, хөлдөөсөн гэх мэт хадгалсан бэлдэц огт байдаггүй гэсэн үг. Зөвхөн шинээр нь хэрэглэгчдийн гарт хүлээлгэн өгдөг.

### Та хамгийн анх хэнд

## бялуу хийж өгсөн бэ?

-Хамгийн анх нөхрөө Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад үүрэг гүйцэтгээд ирэхэд нь аарцтай бялуу хийж өгч байлаа. Одоог хүртэл тэр бялууны амт, үнэр миний сэтгэлээс гардаггүй юм.

## Гэрээр үйлдвэрлэл явуулахад төвөгтэй асуудал гарч байсан уу?

-Мэдээж гаралгүй яах вэ. Түүхий эд материалын хомсдол, үнийн өсөлт зэрэг асуудлууд тохиолддог. Коронавирус дэгдсэнээс үүдэн манай улс хилээ хаасан энэ үед түүхий эд материалын үнэ нэмэгдсэн. Гэтэл хэрэглэгчид хоёр гурван жилийн өмнө байсан шигээ санаж хуучин үнээрээ л бараагаа авахыг хүсдэг. Ер нь гар аргаар хийсэн (артизан) бялуу яагаад бусад үйлдвэрийн бялуунаас үнэтэй, илүү өвөрмөц байдаг зэргийг бусдад таниулахыг хичээдэг. Би австрали, америк, герман мэргэжилтнүүдээс онлайн сургалт авч, бүтээгдэхүүнээ хэрхэн төгс хийх талаар судалж, туршлага хуримтлуулсан.

## Яагаад артизан бялуу бусад бялуунаас онцгой, өвөрмөц байна вэ?

-Артизан бялууны хувьд үйлдвэрийн бялуунаас илүү үнэтэй. Үйлдвэрийн бялуу нь олон тоогоор хийгдэж, эрсдэлийг багасгахын тулд бүхий л шат дамжлагыг машинаар орлуулж хийдэг. Тэр хэрээрээ хяналт шалгалт, чанарын албаны дарга гээд өчнөөн хүмүүс ажилладаг. Харин артизаны хувьд нэг бялуунд зарцуулах хугацаа нь урт, хөдөлмөр их шаарддаг. Мөн илүү төвлөрч бүх шат дамжлагууд гар ажиллагаа ихтэй учраас үйлдвэрийн бялуунаас илүү өнгө үзэмжтэй байдаг юм.

## Ямарваа нэгэн асуудал тулгарахад хэрхэн даван туулдаг вэ?

-Асуудлаа танин мэдэх хэрэгтэй. Хүн ямар нэгэн асуудал тулгарахаар айх, сандрах мэдрэмжийг авдаг. Дараа нь тэрхүү мэдрэмжийг өмнө нь

авч байсан уу гэдгийг өөрөөсөө асуух хэрэгтэй. Өмнө нь авч байсан бол тэр мэдрэмжийг танин "ямар ч асуудалгүй юм байна" дахиад даваад л гарна гэж өөрийгөө зоригжуулдаг. Асуудлаа таньж мэдэхээр бүхий л зүйлийг хүлээн зөвшөөрч түүнд бэлтгэлтэй болчихдог.

## Гэр бүлийнхэн тань хэр дэмждэг вэ?

-Хамгийн сайн дэмждэг хүмүүс бол манай гэр бүлийнхэн. Бялууны хэв, жин, хутгуур зэрэг анхны хэрэгслүүдийг тэд анх бэлэглэж байсан. Нөхөр маань хүргэлтэд явж, хүүхдүүд минь өөрийн санаа бодол, сэтгэгдлээ сайн илэрхийлдэг. Жишээ нь, энэ бялуу карамельтай байвал илүү гоё юм байна, энэ шоколадны дээд талыг жимсээр бүрчих гэх мэт. Гэр бүлийнхэн маань миний үнэнч туслахууд юм.

## Артизан бялууны талаарх хүмүүсийн сэтгэгдэл хэр байна вэ?

-Гэрээрээ бялуу хийж байгаа бүхий л хүн артизан бялууг үйлдвэрлэдэг гэсэн үг. Зарим хэрэглэгч артизан бялууг үйлдвэрийн бялуутай эндүүрэн ихээхэн шүүмжилдэг. Гарын доорх материалыг ашиглан артизан бялууг илүү чанартай, шинээр нь хэрэглэгчдэд хүргэдэг гэдгийг сайн ойлгож

хандах хэрэгтэй.

## "Bitter sweet жор" хэмээх дэвтэр нь ямар зорилготой вэ?

-“Амтаар цаг хугацааны аялал хийж болдог” гэсэн үгээр төлөөлүүлж дөрөв, таван жилийн өмнө анх санааг нь гаргаж байсан. Өмнө нь ямар ч хамаагүй дэвтэр дээр өөрийнхөө жорыг бичихдэг байлаа. Хүн болгонд зориулсан жорын дэвтэр гаргаад өөрсдийн туршлагыг бичээд хүүхдүүдээ өвлүүлэх хэрэгтэй гэж бодож хэвлүүлсэн юм. Эмээ, ээжийнхээ хийдэг байсан амтаны жорыг л тэмдэглэхчлэн өөрт үлдэх “үнэт эрдэнэ” гэж бодоод тэмдэглэж авсан.

## Одоо хийхээр төлөвлөж байгаа ажил бий юу?

-Ном бичихээр зэхэж эхлэлийг нь тавьсан. Бялуу хийгээд найман жилийн хугацааг өнгөрөөхдөө өөрийн хураан авсан бүх мэдлэг, туршлага болоод амжилтаа номдоо шингээхийг хүсэж байна.

## Нөхөр тань энхийг дэмжиж ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед ар гэрийнхээ асуудлыг хэрхэн зохицуулж байсан бэ?

-Нөхцөл байдалд дасан зохицож амьдардаг. Зургаагаас дээш сар бүхий л ачааг нуруун дээрээ үүрч явдаг хүчирхэг, тэвчээртэй эмэгтэйчүүд манай

улсад олон байдаг учир тэднээс урам авч аливаа асуудлыг бүрэн шийдвэрлэж чаддаг. Хүүхдүүд өсөхийн хэрээр асуудлууд томордог гэдгийг сүүлийн үүрэг гүйцэтгэхэд нь ойлгосон. Коронавирусийн халдвар гарснаар ганцаараа онлайн хичээлийг нь бэлдүүлэхийн сацуу бүтээгдэхүүнээ хийнэ гэдэг амаргүй байсан. Гэхдээ асуудал гэж харалгүй мэдрэмждээ хөтлөгдөн даван туулсан.

## Таны бодлоор тангараг өргөсөн хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

-Эх орондоо үнэнчээр тангараг өргөсөн хүнийг хэлэх байх. Тангараг өргөсөн эр хүний тангараг өргөсөн гэргий нь гэж өөрийгөө бодож явдаг. Эх орноо хамгаалдаг, эх орныхоо төлөө амь биеэ өгөхөөс буцдаггүй цэрэг эрийн гэргий нь болохоор өөрийн гэр бүлээ эх оронч гэж тодорхойлно. Эх орныхоо төлөө хий хоосон ярьж, цээжээ дэлддэг бус харин үйлдлээрээ харуулдаг, гаргасан шийдвэр нь эх орныхоо төлөө байдаг эрхмүүдийг тангараг өргөсөн хүмүүс гэж нэрлэдэг байх.

## Ярилцлага өгсөнд баярлалаа. Таны цаашдын ажил, хөдөлмөрт амжилт хүсье.

Оюутан А.ДОРЖХАНД

## Ахмад үе

# БАГА ДАРГА НАРЫГ БЭЛТГЭХ СУРГУУЛИЙН БАТАЛЬОНД НОМЫН БАГШААР АЖИЛЛАСАН ЖИЛҮҮД

Миний бие 1958 онд Улаанбаатар хотын Багшийн сургуулийг дүүргээд төрөлх нутаг Увс аймгийн Хяргас суманд 1960 он хүртэл багшилж байтал цэрэгт дуудагдан Улаангом хот руу орж эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн. Энэ үед Улаанбаатар хотоос цэрэг татлагын комиссоор томилогдож ирсэн хошууч Г.Чимид "Тусгай мэргэжлийн бүрэн дунд сургууль төгссөн залуу боловсон хүчнүүдийг цэргийн офицер болгох тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарсан учраас цэргээс чөлөөлөх тухай яриа байхгүй гэснээр бусад залуусынхаа хамт их хотыг зорьсон юм. Бид замдаа тав хоноод нийслэлийн Шархадны больницны наана орших хоёр өндөр хэмээх газарт байрласан ба биднийг шинэ цэргийн карантинд буухад Сайд нарын Зөвлөлд ажиллаж байсан том ах Ц.Нямаа, эхнэртэйгээ намайг угтаж уулзав. Төд удалгүй Цэрэг татлагын комиссын дарга, хошууч Г.Чимид Сургалтын төвийн удирдлагад Увс аймгийн Хяргас сумаас Ц.Төвөө гэдэг багш ирсэн тухай танилцуулсан бололтой, ахмад бас нэг түрүүч миний нэрийг дуудан танилцсан юм.

Эдгээр офицер, түрүүч хоёр тухайн үеийн Ардын Армийн 029 дүгээр анги буюу Бага дарга нарыг бэлтгэх сургуулийн Сургалт ангийн дарга, дэд хурандаа С.Сэр-Одод танилцуулан хүлээлгэн өгөв. Дэд хурандаа С.Сэр-Од энэ үед намайг түрүүч цолтой тасгийн захирагч бөгөөд бичиг үсэг үл мэдэгч

цэрэг, түрүүч нарын номын багшаар томилж билээ.

Тухайн үед Цэрэг ба НАХХЭЯ-ны Сайдны орлогч бөгөөд Ардын цэргийн командлагчийн 1956 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 045 тоот тушаалаар Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит, Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цэргийн ерөнхий сургуулийг татан буулгажээ. Харин энэ сургуулийн дайчин уламжлал хадгалагдсаар байсан бөгөөд сайдын 1959 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 124 тоот тушаалаар Жанжин Сүхбаатарын нэрэмжит, Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цэргийн ерөнхий сургуулийн Байлдааны улаан туг, одонг Ардын цэргийн бага дарга нарыг бэлтгэх сургуульд шилжүүлэн өгсөн түүхтэй юм. Энэ үед Бага дарга нарыг бэлтгэх сургуулийн захирлаар дэд хурандаа Д.Сэрээнэн, Улс төрийн хэлтсийн даргаар дэд хурандаа Н.Түмэн-Өлзий, Хангалтын орлогоор хошууч Ч.Жүгдэр, офицерууд бэлтгэх курсийн захирлаар дэд хурандаа Д.Баадай, сургалт ангийн даргаар дэд хурандаа С.Сэр-Од, сургалтын хэлтсийн туслахаар ахмад М.Төмөр-Очир нар ажиллаж байлаа.

Тус сургууль нь мотобуудлагын анги, салбаруудад төгсөж очоод ажиллах бага даргын нэг рот, түүний захирагч нь ахмад Г.Гомбодорж, ротын улс төрийн орлогч нь ахмад Т.Баатар (одоогийн хошууч генерал), барилгын цэргийн анги, салбаруудад төгсөж очоод ажиллах бага даргын нэг роттой, ротын захирагч нь

хошууч Ш.Мишигваа, улс төрийн орлогч нь ахлах дэслэгч З.Дашрэнцэн нар ажиллаж байсан ба харин манай салааны захирагчаар дэслэгч Н.Агваанрэнцэн ажилладаг байсан юм.

Би хошууч Ш.Мишигваагийн ротод 20-иод цэргийг удирддаг түрүүч цолтой тасгийн захирагчаар томилогдсон ба бичиг үсэг бага мэдэгч цэрэг, түрүүч нарын номын багшаар долоо хоногт дөрвөн удаа 2-4 цагаар хичээл зааж, нэг өдөр нь Офицеруудын ордонд заах аргын семинарт суух ба үлдсэн нэг өдөрт нь конспект бичиж батлуулах, байлдагч, түрүүч нарт давтлага, зөвлөгөө өгөх журмаар ажилладаг байлаа. Офицер бэлтгэх курсийн захирал Д.Баадай нэг өдөр намайг офицерын курст суралцахыг хүсэхэд "Би халагдаж багшийнхаа ажлыг хийх буюу хэрэв Зөвлөлт Холбоот Улсад Цэргийн дээд сургуульд явуулах боломж гарвал түүнд явах бодолтой байгаа"-гаа ярьсан юм.


Энэ үед миний удирдсан тасаг таван сарын дараа тэргүүний тасагаар шалгарч, зургаан сарын дараа бичиг үсэг бага үл мэдэгч цэрэг, түрүүч нар бүгд бичиг үсэгтэн болсноор ротын ханын сонинд миний ажлын амжилт, үр дүнгийн талаар бичигдсэн ба ангийн Байлдааны дэлгэц тугийн дэргэд зургаа авхуулан сайшаагдаж байлаа. Тус сургуулиас хожмоо нэрд гарсан олон арван бага дарга нар төгсөж гарсны дотор Говь-Алтай аймгийн харьяат ахлах түрүүч Н.Жамбаа, Увс аймгийн харьяат ахлах түрүүч П.Намсрай, Завхан аймгийн ахлах

түрүүч Ч.Бямбаа, Баянхонгор аймгаас Н.Ширэндэв нарын залуусыг онцлох учиртай.

Энд нэгэн сонирхолтой дурсамжийг өгүүлэхэд, Ардын цэргийн бага дарга нарыг бэлтгэх сургууль нь одоогийн "Цайз" захын зүүн урд орших Талхан заводоос хүнсний хуурай хэрэглээ татан авдаг байсан ба тэрхүү ажлыг байлдагч Балжинням хар халзан ба бор халзан гэх хоёр хайнагийн шараар гүйцэтгэдэг байлаа. Энд өгүүлж буй хоёр шар нь ахмад цолтой байсан нь бидэнд сонин санагддаг юм. Түүнээс гадна бор халзан хайнагийн эвэр нь тахиралдан хацар руу нь хатгадаг байсан тул түүний эвэрийн үзүүрийг тайрах ажил байнга гардаг байж билээ.

Энэ үед 1961 оны хавраас сургалт ангийн дарга, дэд хурандаа С.Сэр-Од намайг өөрийнхөө мэдэлд авч бичиг хэргийн ажлыг гүйцэтгүүлж байлаа. Тэр бээр надад бямба гарагийн орой 19.00 цагт Улаанбаатар хот дахь гэр рүүгээ очоод даваа гарагийн өглөө 08.30 цагт сургуульдаа ирж байх зөвшөөрлийг өгч билээ. Энэ нь цаашид намайг Зөвлөлт Холбоот Улсын Цэргийн дээд сургуульд суралцуулах бодолтой байсны нэгэн илрэл бөгөөд би бээр Ардын хувьсгалын 40 жилийн ойн баярын өмнөхөн эрүүл мэндийн үзлэгт тэнцэн цэргийн дүрэмт хувцасныхаа хэмжээг өгснөөр 1961 оны 8 дугаар сард Алс дорнодын Цэргийн ерөнхий дээд сургуулийг зорьсон юм даа.

Монгол Улсын гавьяат багш Ц.ТӨВӨӨ



## Дугаарын зочин



**Юуны өмнө тантай уулзсандаа баяртай байна. Танд "Airs Sport Media Awards" шагнал хүртсэнд тань баяр хүргэе. Та манай сонины уншигчдад өөрийгөө танилцуулахгүй юу?**

-Би Завхан аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн. Аавыг минь Б.Батсүх гэдэг. Хөвсгөл аймгийн уугуул бөгөөд барилгын инженер мэргэжилтэй хүн байсан. Солонготын давааг бүтээн байгуулахад удирдаж явсан гэдгээр нь бахархдаг. Намайг хоёр настай байхад аав маань өвчний улмаас нас барж манайх Улаанбаатар хотод ирэн суурьшсан. Харин намайг өсгөсөн аав маань Барилгын цэргийн 017 дугаар ангийн офицер Чулуунбаатар гэдэг хүн байсан. Намайг өдий зэрэгтэй хүн болгон хүмүүжүүлсэн ачтан.

**Таны үндсэн мэргэжил юу вэ, яагаад гэрэл зураг сонирхох болсон бэ?**

-Би барилгын инженер мэргэжилтэй. Харин гэрэл зураг авах нь миний хобби. Ахлах ангид байхдаа найз нөхдийнхөө зургийг авч үүндээ урамшин гэрэл зураг сонирхох болсон. Түүнээс хойш сонирхлоо мэргэжил болтлоо хөгжүүлэн ажилласан хүн гэж хэлж болно.

**Ааваараа бахархдаг байсан нь мэдээж ...**

-Тэгэлгүй яах вэ. Тухайн үеийн Барилгын цэргийн анги, салбарууд манай орны хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр оруулж байлаа. Тухайлбал, Засгийн газрын ордон болон олон улсын хүүхдийн "Найрамдал" зусланг шинээр барих зэргээр бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцож байсан юм. Тиймээс ааваараа маш их бахархаж, хүндэлж явдаг. Энэ цаг үед Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, тэр дундаа барилгын цэрэг төмөр замын

# Ч.Ганбат: ОЛИМПЫН ИХ НААДМЫГ СУРВАЛЖЛАХ НЬ СПОРТЫН ГЭРЭЛ ЗУРАГЧНЫ ХУВЬД ОРГИЛ ҮЕ

Монголын спортын сэтгүүлчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, спортын гэрэл зурагчин Ч.ГАНБАТТАЙ ярилцлаа. Тэрээр хоббигоо мэргэжил болтлоо хөгжүүлэн "Оны шилдэг гэрэл зураг" уралдааны Гран при буюу тэргүүн байрын шагналыг хүртэж байсан юм.

бүтээн байгуулалтад гар бие оролцож байгааг хараад бахархаж явна.

**Яагаад спортын гэрэл зургаар дагнах болсон бэ?**

-Ер нь гэрэл зургийн төрөл жанр олон янз байдаг. Байгалийн, баримтат, сэтгүүлийн гэх мэт олон төрөл байдаг бөгөөд би бээр спортын гэрэл зургийг ихэд сонирхох болсон. Спортын гэрэл зураг бол техник, авхаалж самбааг шаардсан хэцүү төрөл юм. Энэ төрлөөр хүмүүс тэр болгон дагнаад байдаггүй. Тиймдээ ч миний сонирхлыг илүү ихээр татах болсон. Зураг авахын тулд тухайн тамирчнаа сайн мэдэрч, техникийг нь ойлгодог байх хэрэгтэй. Энэ нь тийм ч амар зүйл биш.

**Зураг авахад амаргүй байсан цаг үеэ дурсвал ...**

-Анх мандатгүй гэрэл зураг авдаг байсан учраас аливаа уралдаан, тэмцээн, ёслолын ажиллагаанаас хөөгдөж гарах тохиолдол олон гардаг байсан. Авсан зургууд маань чанарын шаардлага хангахгүй тохиолдол ч олон байсан. Тэр үе л хамгийн хэцүү байсан болов уу.

**Т о м о о х о н газруудаар явж зураг дарахад мандат хэрэг болдог гэж сонссон. Та хэдийд мандатаа авсан бэ?**

-Анх Монголын спортын эвлэлд гишүүнээр элсэж эрхтэй болсон. Ингэснээр томоохон байгууллага, албан газруудаар явж хүссэн зургаа дарах боломжтой болж байна гэсэн үг. Эрхээ авснаар өөрийгөө хөгжүүлэх, алхам алхмаар урагшлах боломж маань нээгдсэн гэж боддог. Цаашлаад албан ёсны эрхтэйгээр Европ, Ази тивийн орнуудад зохиогдож буй тэмцээнүүдийг сурвалжлах боломж нээгдсэн. Тэр дундаа хүн төрөлхтний эв найрамдлын бэлгэ тэмдэг болсон Олимпын наадмыг дөрвөн удаа сурвалжилж байсан маань спортын гэрэл зурагчин болсон миний хувьд хамгийн сайхан үе.

**Анх хэдэн оны Олимпын наадмыг сурвалжилж байсан бэ?**

-Олимпын их наадмыг сурвалжлах нь спортын гэрэл зурагчны хувьд оргил үе нь байдаг. Энэ нь эхэндээ мөрөөдөхөөс цаашгүй зүйл байлаа. Гэтэл энэхүү эрхийг авна гэдэг миний хувьд маш том хариуцлага, нэр хүнд болж өгсөн. Цаашлаад эх орноо төлөөлөн явж байгаа тамирчдынхаа түүхэн амжилтыг гэрэл зурагт буулгана гэдэг маш том хариуцлага, хүндлэл мэт санагдаж билээ. Тэрхүү өндөр хариуцлагатай нэр хүндээ дөрвөнтөө үүрч одоо тав дахь эрхээ авсан бөгөөд Токиогийн олимпод явахаар болсондоо туйлын баяртай байна.

**Та "Уурга шүүрлээ" хэмээх зургаараа спортын сэтгүүлчдийн холбооноос гуравдугаар байрын шагнал авсан. Та тэрхүү тэмцээний талаар сонирхуулаач ...**

-Энэхүү өндөр босготой тэмцээнээс шагнал хүртэнэ гэдэг нэр төрийн хэрэг байсан. "AIRS Sport Media



Awards" бол дэлхийн томоохон тэмцээнүүдийн нэг бөгөөд 1924 оноос эхлэлтэй. Өдгөө 2019 онд 83 дахь удаагаа зохиогдсон юм. Дэлхийн 125 орны спортын гэрэл зурагчид 1746 ширхэг бүтээлээр өрсөлдсөн. Тэднээс шалгарч дэлхийн том том агентлагуудын гэрэл зурагчдын эгнээнд багтаж гуравдугаар байрын шагналыг хүртсэн нь үнэхээр гайхалтай үйл явдал байсан.

**Танд дахин баяр хүргэе. Цаг гарган бидэнтэй ярилцсанд баярлалаа. Танд ажлын өндөр амжилт хүсье.**

Оюутан Г.НАНДИНТУЯА

## ГЭРЭЛ ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ



1945 оны Чөлөөлөх дайнд хөсөг тээврийн Нэгдүгээр хорооны тэмээн хөсөг цуваа

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас мэдээлж байна


**УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТ ЗӨРЧСӨН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ**

**14.7 дугаар зүйлийн 14.7.57 дахь хэсэгт:**

"Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн бол хүнийг 20.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200.000 төгрөгөөр торгоно" гэсэн заалттай.

**ЗӨРЧИЛ ГАРГАГЧ НАРТ ХЯНАЛТ ТАВИХ ХЭЛБЭР НЬ:**

- АЛБА ХААГЧИД БИЕЧЛЭН
- ХЯНАЛТЫН КАМЕРААР



**СОЁМБО СОНИН**  
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч  
Хурандаа  
Батжаргалын  
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин  
релакцад бэлтгэж,  
"Соёмбо принтинг" хэвлэх  
үйлдвэрт хэвлүүлэв.

\*Зар, рекламг хямд нийтэлнэ.

\*Зар, рекламг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.

\*Зохиогчийн үзэл бодол сонинг нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.

\*Тус сонинг мэдээллийг нэр заан ашиглаж болно.

## ЭМГЭНЭЛ

**ЧӨЛӨӨНД БАЙСАН ХУРАНДАА П.ХАЯНХЯРВАА (1935-2020)**



Пүрэвжавын Хаянхярваа өвчний улмаас таалал төгсөж, их урлагт нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

П.Хаянхярваа 1935 онд Улаанбаатар хотноо мэндэлсэн. 1955 онд Офицерын сургууль, 1961 онд Москва хотноо П.И.Чайковскийн нэрэмжит Хөгжмийн их сургуулийн Цэргийн хөгжмийн факультетийг дүүргэсэн. 1947 оноос Цэргийн ерөнхий сургуулийн Хөгжмийн салаанд сурагч, 1950 онд Үлгэр жишээ хөгжмийн анхны хөгжимчдийн нэг, 1955-1957 онд Монголын Ардын Армийн Дуу бүжгийн ансамбльд хөгжимчнөөр ажиллаж байгаад 1957 оноос Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимд Туслах удирдаачаар дэвшин, офицерын албанд томилогдсон юм.

Тэрээр 1961-1972 онд Монголын Ардын Армийн Дуу бүжгийн ансамбльд Найруулагч, Уран сайхны удирдагч, 1972-1978 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн хөгжмийн албаны дарга бөгөөд Ардын Армийн Ерөнхий удирдаач-Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн Уран сайхны удирдагч, 1978-1981 онд Улсын дуурь бүжгийн академик театр Уран сайхны удирдагч, 1981 оноос Монголын Ардын Армийн Дуу бүжгийн ансамбльд Уран сайхны удирдагч, 1990 оноос Үндэсний дуу бүжгийн "Түмэн эх" чуулгын дарга, 1995 оноос Цагдаагийн ерөнхий газрын харьяа Дуу бүжгийн "Сүлд" чуулгын даргаар тус тус ажиллаж байв.

Удам залгасан цэргийн хөгжмийн удирдаач тэрээр "Цэргийн нөхөр

Цэрэнтэйгээ", "Дайчин алдарт эскадриль", "Их говийн гарнизон", "Ардын арми", "Хонгор нутгийн түмэндээ" зэрэг ард түмэнд алдаршсан олон арван дууны бүтээл, "Украин бүжгийн чуулбар", "Төрсөн өдөр", "Анчин" гэх мэт бүжгийн хөгжим, "Цэргийн хүү", "Хүндэтгэн угтах марш", "Дотоодын цэргийн жавхлант марш" гэхчлэн үлээвэр найрал хөгжимд зориулсан дан маршууд, магтуу, удиртгал хөгжим, киноны болон циркийн хөгжим зэрэг 1000 гаруй бүтээлийг туурвиж, олон зуун бүтээлийн найруулга хийжээ.

Мөн 1959 оноос эхлэн хөгжмийн урлагийн болон бусад сэдэвт ном, зохиол 40 гаруйг хянан тохиолдуулж, хөгжмийн шүүмж судлалын талаар олон арван нийтлэлийг бичсэн нэрт эрдэмтэн байлаа.

Авьяас билигт хөгжмийн зохиолч П.Хаянхярваа нь Хөгжим бүжгийн дунд сургууль, Соёлын коллеж, "Их засаг" их сургууль, "Бэрс" дээд сургууль, "Мюзик холл" дээд сургуулиудад багшилж, олон мянган хөгжмийн болон соёл, урлагийн мэргэжилтэн бэлтгэх үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулсан шилдэг эрдэмтэн, профессор багш юм.

Монголын соёл, урлагийг хөгжүүлэх, хөгжмийн урлагийн залгамж халааг бэлтгэх, цэрэг-эх орны сэдэвт уран бүтээлийн өв санг баяжуулахад оруулсан түүний үнэтэй хувь нэмрийг нь төр, засгаас үнэлэн Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Халхын голын ялалтын түүхт ойн медалиуд, Улс хувьсгалын болон Ардын Армийн ойн медаль болон бусад шагналаар шагнаж, 1979 онд Урлагийн гавьяат зүтгэлтэн, 2008 онд Ардын жүжигчин цолыг тус тус хүртээжээ.

Ардын жүжигчин П.Хаянхярваагийн дундаршгүй авьяас билиг, өргөн их мэдлэг, мятаршгүй дайчин чанар, хүнлэг сайхан сэтгэл, Монголын их урлагийн төлөө зориулсан нэр их хөдөлмөр зүтгэл, туурвисан бүтээл бүхэн нь бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

Урлагийн тэнгэрт тодоос тод гэрэлтсэн аугаа их хүмүүн таны газарт босгосон бүтээлийн суварга, дэлхийд үлдээсэн ариун үйлс бүхэн ашид мөнх орших болно.

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА, ЗХЖШ-ЫН ҮЛГЭР ЖИШЭЭ ҮЛЭЭВЭР НАЙРАЛ ХӨГЖИМ, БХЯ, ЗХЖШ-ЫН АХМАДЫН ХОРОО**

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018

И-мэйл хаяг:  
Mil\_newssoyombo@yahoo.com  
Утас: 70001029